



Монгол Улсын  
Шинжлэх Ухааны Академийн  
Түүх, археологийн хүрээлэн



Япон улсын  
Тохоку Их сургуулийн  
Зүүн хойд Ази судлалын төв



БНХАУ-ын ӨМӨЗО-ны  
Багшийн Их сургуулийн  
Аялал жуулчлалын дээд  
сургууль



ОХУ-ын Бүгд Найрамдах Саха улс  
Оросын ШУА-ийн Сибирийн  
салбарын Хүмүүнлэгийн ба  
Умардын цөөн тоот үндэстний  
судалгааны хүрээлэн

## ЕВРАЗИЙН НҮҮДЭЛЧДИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ: ТӨР, НИЙГЭМ, СОЁЛ

Олон улсын эрдэм шинжилгээний хурал  
*Монгол улс. Улаанбаатар хот*  
*2018 оны 9 сарын 6-7*

**ХӨТӨЛБӨР  
ИЛТГЭЛИЙН ХУРААНГУЙ**

## 2018 оны 9 сарын 6. Пүрэв гариг

### НЭГДСЭН ХУРАЛДААН

#### Монгол улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны Хурлын танхим. 4 давхар

- 9.00-9.30: Хурлын бүртгэл
- 9.30-9.40: Хурлын нээлт - ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D), профессор С.Чулуун

#### Мэндчилгээ

- 9.40-9.45: Монгол улсын Ерөнхийлөгч Х.Баттулга
- 9.45-9.50: Монгол улсын БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа
- 9.50-9.55: Монгол улсын ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл
- 9.55-10.00: Япон улсын Тохокү Их сургуулийн Зүүн хойт Азийн судалгааны төвийн профессор, доктор Ока Хироки
- 10.10-10.40: Үндсэн илтгэл:  
“XX зууны Монголын түүхийн судалгааны тэргүүлэх их эрдэмтэн”  
(Ж.Болдбаатар. ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, академич)

**2018 оны 9 сарын 6. Пүрэв гариг**

**НЭГДҮГЭЭР САЛБАР.  
“АКАДЕМИЧ Ш.НАЦАГДОРЖ БА МОНГОЛЫН ТҮҮХ СУДЛАЛ”**

**Соёлын Төв өргөө, Г корпус. 3 давхрын хурлын танхим**

**ҮДЭЭС ӨМНӨХ ХУРАЛДААН  
Хурлын дарга: Г.Чулуунбаатар**

- 11.00-11.20: “Академич Ш.Нацагдорж ба түүх судлалын байгууллага”  
(С.Чулуун, Монгол улс)
- 11.20-11.40: “Хубилай хааны түүхэн үүргийг үнэлэх талаарх академич Ш.Нацагдоржийн үзэл баримтлалын тухайд”  
(С.Цолмон, Монгол улс)
- 11.40-12.00: “Академич Ш.Нацагдорж ба дундад зууны Монголын түүхийн судалгаа”  
(А.Пунсаг, Монгол улс)
- 12.00-12.20: “Академич Ш.Нацагдоржийн Монголын түүхийн сурвалж судалгааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр”  
(Н.Ариунгуа, Монгол улс)
12. 20-12.40: “Чингис хааны цэргийн түүхийн судалгаа: өнөө үе”  
(Ж.Базарсүрэн, Монгол улс)
- 12.40-13.00: **Хэлэлцүүлэг**
- 13.00-14.00: **Үдийн завсарлага**

**ҮДЭЭС ХОЙШХИ ХУРАЛДААН  
Хурлын дарга: Н.Хишигт**

- 14.00-14.20: “Дундад эртний Монголчуудын нийгмийн байгууллын судалгаанд академич Ш.Нацагдоржийн оруулсан хувь нэмэр”  
(П.Дэлгэржаргал, Монгол улс)

- 14.20-14.40: “Академич Ш.Нацагдорж ба XVIII-XIX зууны Монголын түүх бичлэг”  
(Д.Баярсайхан, Монгол улс)
- 14.40-15.00: “Академич Ш.Нацагдорж Монголын нийгэм-улс төр, эрхийн сэтгэлгээний түүхийг судалсан нь”  
(А.Жамбал, Монгол улс)
- 15.00-15.20: “Академич Ш.Нацагдоржийн бүтээлүүд дэх Монголын эрх зүйн түүхийн асуудлууд”  
(Б.Баярсайхан, Монгол улс)
- 15.20-15.40: “Монголын орчин үеийн түүхийн судалгаа ба академич Ш.Нацагдорж”  
(Б.Пунсалдулам, Монгол улс)
- 15.40-16.00: **Цайны завсарлага**
- Хурлын дарга: Н.Ариунгуа**
- 16.00-16.20: “Ш.Нацагдорж ба Монголын угсаатны зүйн судалгаа”  
(Г.Цэрэнханд, Монгол улс)
- 16.20-16.40: “Монгол, Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедици”  
(Д.Цэвээндорж, Монгол улс)
- 16.40-17.00: “Академич Ш.Нацагдорж Монгол-Зөвлөлтийн харилцааны тухайд”  
(Б.Энхбаяр, Монгол улс)
- 17.00-17.20: “Зохиолч Ш.Нацагдорж”  
(Б.Мөнхбаяр, Монгол улс)
- 17.20-17.40: “Шагдаржавын Нацагдорж - кино зохиолч”  
(Г.Жигжидсүрэн, Монгол улс)
- 17.40-18.00: “Академич Ш.Нацагдоржийн бичиг, захидлын өв”  
(Д.Год, Монгол улс)
- 18.00-18.20: **Хэлэлцүүлэг**
- 19.00-20.30: **Оройн зоог**

**2018 оны 9 сарын 6. Пүрэв гариг**

**Соёлын Төв өргөө, Г корпус. 6 давхрын хурлын танхим**

**ХОЁРДУГААР САЛБАР**

**“Евроазийн нүүдэлчдийн түүхэн замнал: төр, нийгэм ба соёл”**

**ҮДЭЭС ӨМНӨХ ХУРАЛДААН**

**Хурлын дарга: Э.Хуриц**

- 11.00-11.20: “Манжийн үеийн Монголд Манжийн хууль эс хэрэгжсэний учир”  
(Ока Хироки, Япон улс)
- 11.20-11.40: “Хүний бие худалдахыг цаазалсан Манжийн үеийн Монгол цаазын бичиг”  
(Хагихара Маморү, Япон улс)
- 11.40-12.00: “Дайчин гүрний үе дэх Монголын нийгмийн “Дарханы дүрэм”-ийн судлал” (Тайцзун хаанаас Найралт Төв хааны үе хүртэл)  
(Насан-Өлзий, БНХАУ)
- 12.00-12.20: “Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны Хууль Зүйлийн Бичгийн доторх нэг тогтоолын тухай”  
(Сато Нориюки, БНХАУ)
- 12.20-12.40: “Халхын үйсэн цааз” дахь XVI-XVII зууны Монголын түүхэнд холбогдох зарим мэдээ”  
(Э.Жигмэддорж, Монгол улс)
- 12.40-13.00: **Хэлэлцүүлэг**
- 13.00-14.00: **Үдийн завсарлага**

**ҮДЭЭС ХОЙШХИ ХУРАЛДААН**

**Хурлын дарга: Б.Нацагдорж**

- 14.00-14.20: “Исторический опыт реформирования регионального управления на северо-востоке Российской империи (на примере Якутии) и в Монголии под власть Цин в 1720-е гг.- вторая половина XVIII в”  
(А.А.Борисов ОХУ)

14.20-14.40: “Степные думы - органы самоуправления бурят Российской империи в XIX в.”  
(Б.З.Нанзатов, ОХУ)

14.40-15.00: Бүгд Найрамдах Буриад Улсын номын санд байгаа Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын материал: “Dotuγadu Mongγul-un arad-un qubisγaltu nam-un ündüsün jorilta”-ын тухай  
(Хөхбаатар, Япон улс)

15.00-15.20: “Хаант Оросын төмөр зам хийгээд Ганжуур сүмийн зах арилжаа”  
(Дараахүү, БНХАУ)

15.20-15.35: **Хэлэлцүүлэг**

15.35-15.50: **Цайны завсарлага**

#### **Хурлын дарга: Хагихара Маморү**

15.50-16.10: “Чин улсын үеийн Монгол дахь “тэжээх”-ийн асуудалд: Монголын засаг захиргааны асуудлаас”  
(Хориүчи Каори, Япон улс)

16.10-16.30: “Чин улсын үеийн Монголын нийгэм дэх инж дагуулах ёс”  
(Бүрэнсод, БНХАУ)

16.30-16.50: “Монголын тамгатай хутагтуудын шавь хувилгаадын тухайд”  
(Л.Алтанзаяа, Монгол улс)

16.50-17.10: **Хэлэлцүүлэг**

#### **Хурлын дарга: Ц.Цэрэндорж**

17.10-17.30: “Чин улсын харьяан дахь монголчуудын түүхэн ухамсар: монгол ноёдын бичиг харилцааны жишээгээр”  
(Б.Нацагдорж, Монгол улс)

17.30-17.50: “Аруг Юннань вангийн Тай Сан Гин номыг дэлгэрүүлэх линжи бичиг”-ийн тугтам шинжилгээ  
(Чуан Рун, БНХАУ)

17.50-18.10: “Гэрээс эрдмийн сан оршивай” хэмээх судрын тухай шинжилгээ  
(Гэн Чуан, БНХАУ)

18.10-18.30: “Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны гурван нутгийн зургийн тухай  
(Ш.Мөнхбаатар, Монгол улс)

18.30-18.50: **Хэлэлцүүлэг**

**2018 оны 9 сарын 7. Баасан гариг**  
**Соёлын Төв өргөө, Г корпус. 3 давхрын хурлын танхим**

**ХОЁРДУГААР САЛБАР**

**“Евроазийн нүүдэлчдийн түүхэн замнал: төр, нийгэм ба соёл”**

**ҮДЭЭС ӨМНӨХ ХУРАЛДААН**

**Хурлын дарга: Чуан Рун**

- 9.00-9.20: “Монголын боржигин овогт язгууртад харилцан ураг элгэн бололцсон учраас сэдэвлэх нь”  
(Э.Хурц, БНХАУ)
- 9.20-9.40: “Халхын Еншөөв тайж нарын уг гарвалын тухай”  
(Н.Хатанбаатар, Монгол улс)
- 9.40-10.00: “Чин улсын үеийн Онниуд баруун хошууны ван, гүн, тайж нарын Гэрийн үеийн бичмэлийг шинжлэх нь”  
(Юй Хай, БНХАУ)
- 10.20-10.40: “Зүүнгарын хаадын хаан ширээ залгамжлалын түүхийн асуудалд”  
(На.Сүхбаатар, Монгол улс)
- 10.40-11.00: “Шагдар хамба ламд холбогдох түүхэн баримтууд”  
(Боржигин Улаанбагана, БНХАУ)
- 11.00-11.20: **Хэлэлцүүлэг**  
11.20-11.40: **Цайны завсарлага**

**Хурлын дарга: М.М.Содномпилова**

- 11.40-12.00: “On the nature of Chan Yu’s power”  
(Ли Чунмэй, БНХАУ)
- 12.00-12.20: “The Heritage of the Clothing of the Great Mongol Empire and its Influence on the Clothing of the Mongols; The Coats with Horizontal Cross-partition”  
(Ока Ильдико, Япон улс)

- 12.20-12.40: “Монгольские шахматы XIII в.: обнаружение памятника”  
(Сыртыпова С.-Х.Д, ОХУ)
- 12.40-13.00: “Орочу шигүш, Хутуг шигүш болон Доён Урианхай аймаг”  
(Гэсэр, БНХАУ)
- 13.00-13.20: “Ойн урианхай болон Тагна урианхай нь орчин үеийн  
тувачуудын өвөг дээдэс мөн”  
(Бичелдей У.П, ОХУ)
- 13.20-13.40: **Хэлэлцүүлэг**
- 13.40-14.20: **Үдийн завсарлага**

**ҮДЭЭС ХОЙШХИ ХУРАЛДААН**  
**Хурлын дарга: Ока Хироки**

- 14.00-14.20: “Манжийн үеийн өртөө ба Халхын нийгэм: Сайр ус өртөөний  
жишээн дээр”  
(Накамура Ацүши, Япон улс)
- 14.20-14.40: “Чин улсын үеийн Их Зуугийн чуулганы эл өртөөнд холбогдох  
хэдэн асуудал”  
(Хасбагана, БНХАУ)
- 14.40-15.00: “Property and Inheritance of Mongol Nobleman Tabunang in  
Kharchin Region during the Qing”  
(Боржигин Хөхмөчир, БНХАУ)
- 15.00-15.20: “Сакральные элементы правосудия монгольских народов в  
правовых системах Российской и Цинской империй”  
(М.М.Содномпилова, ОХУ)
- 15.20-15.40: “Чин, Иргэн улсын үе дэх Өвөр Монголын өрх амын данс, жич  
түүний үнэ өртөг”  
(Уранцэцэг, БНХАУ)
- 15.40-16.00: **Хэлэлцүүлэг**
- 16.00-16.20: **Хурлын хаалт: С.Чулуун, Ока Хироки, Э.Хурц**



# **ИЛТГЭЛИЙН ХУРААНГУЙ**

Л.Алтанзаяа  
(Монгол улс, МУБИС)

## **Монголын тамгатай хутагтуудын шавь хувилгаадын тухайд**

XVII-XX зууны эхэн үеийн Монголд харьяат шавь нар захирах эрх бүхий тамгатай хутагтуудын байр суурь бэхжихийн зэрэгцээ хувилгаад олширсоор байв. Түүний учир шалтгааныг судлах нь чухал тул тамгатай хутагтуудын шавь хувилгаад болон засаг хошууны хувилгаадын уг эхийг харьцуулан тэдний нийтлэг, ялгаатай талыг тодруулахыг хичээсэн болно. Тухайлбал, XVII зууны сүүлч үед Халхын зарим хувилгааны шавь нараас хошууны төөлүүр дансанд оруулсан ч дараагийн хувилгааныг тодруулсаар байжээ. Халхын Жавзандамба хутагт, Зая бандида хутагт, Чин сүжигт номун хан, Нарбанчин хутагт, Шива ширээт хутагт зэрэг ихээхэн хутагтуудын харьяат шавьд хувилгаад байсан бөгөөд тэднийг хэдэн үе хувилгаан гарснаар нь эрэмбэлдэг байв.

Мөн Халхын зарим хошуунд тамгагүй боловч хутагт цолтой хувилгаад байсан нь бусад хошууны хувилгаадаас хэрхэн ялгагдаж байсныг тодотгууштай юм. Тэдгээр хувилгаадыг Далай лам, Банчин эрдэнэ, Жавзандамба хутагт нар хэний гэр бүлээс хэрхэн тодруулж ямар цол ямба шагнан хүртээж байсныг нягталснаар Монголын тамгатай болон тамгагүй хутагт, хувилгаадын харилцаа хамаарлыг тухайн үеийн засаг захиргааны зохион байгуулалттай уялдуулан тайлбарлаж болох юм.

Н.Ариунгуа

(Монгол улс, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн)

**Академич Ш.Нацагдоржийн  
Монголын түүхийн сурвалж судалгааг  
хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр**

Тус илтгэлд академич Ш.Нацагдоржийн Монголын түүхийн сурвалж судалгааг хөгжүүлэхэд оруулсан гавьяа зүтгэл, хувь нэмэрийг цохон тэмдэглэсэн ба энэ чиглэлээр түүний хийсэн судалгааг үндсэн хоёр чиглэлд хуваасан байна. Үүнд:

а. Монголын түүхэнд холбогдох сурвалж бичиг, данс харааг илрүүлэн судалгаа шинжилгээний ач холбогдлых нь үүднээс үнэлэн нягталж хэвлэн нийтлэн эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан ажил. Тэдгээр нь эрдэм шинжилгээний тайлбар бүхий бие даасан бүтээл болон хэвлэгдсэн;

б. судалгааны зохиол, нэн ялангуяа нэгэн сэдэвт зохиолоо бичихдээ үлэмж тооны архивын данс харааг илрүүлэн ашиглаж, судлан дүгнэж тухайн судалгааны чиглэл, сэдвийн сурвалж судалгааны баазыг баяжуулсан.

Илтгэгч академич Ш.Нацагдоржийн судалгааны гол чиглэл бол Монголын нүүдлийн нийгмийн хөгжлийн үйл явц, онцлогийг нь илрүүлэх судалгаа бөгөөд сурвалж судалгааны ажил нь мөн энэ чиглэлд явагдсаныг тэмдэглээд, Манжийн үеийн сурвалжуудыг уудлан илрүүлж судлан эмхтгэсэн нь тухайн үеийн Монголын нүүдлийн нийгмийг судлах сурвалж судалгааны баазыг бий болгоход чиглэгдэж байсан гэжээ.

Мөн академич Ш.Нацагдоржийн эмхтгэн нийтэлж тайлбар хийсэн Манжийн үеийн сурвалжуудын заримаас, тухайлбал, “Улаан хацарт” (УБ., 1956), “Дөрвөн аймгийн алба тэгшитгэсэн данс” (Ц.Насанбалжирын хамт. УБ., 1962), “Харьяат хошууны дотор дагаж явуулахаар тогтоож тушаасан ухуулах бичгийн уг эх” (УБ., 1960), “То вангийн сургаал” (УБ., 1966), “Монголчуудын өв өвлөх эрх” (УБ., 1971) зэрэг бүтээлүүдийг дурджээ.

Илтгэгч академич Ш.Нацагдоржийн судалгааны бас нэг чиглэл бол Монголын ард түмний Манжийн эсрэг тэмцлийн түүх болохыг онцолж, тухайн чиглэлээр өргөн хэмжээний судалгаа хийж арвин данс тэргүүтнийг судалж эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсныг дурджээ.

Ж.Базарсүрэн

(Монгол улс, Үндэсний Батлан хамгаалахын их сургууль)

## **Чингис хааны цэргийн түүхийн судалгаа: өнөө үе**

Бүхэл бүтэн хоёр зууны турш дэлхий дахиныг төвшитгөж, өстөн дайсан бүхнээ өвдөг сөгтгөж асан дундад эртний монгол цэргийн түүх, түүний дотор Чингис хааны цэргийн түүх олон улсын эрдэмтэн судлаачид, цэргийн мэргэжилтнүүдийн анхаарлын төвд байсаар ирэв.

Гадаад орнуудад Чингис хааны цэргийн түүх, эрдэм ухааныг анхлан цэргийн зорилгоор, тагнуулын аргаар судалж эхэлсэн бөгөөд түүхийн болон цэргийн шинжлэх ухааны үүднээс судлах үйл хэргийг ХХ зууны эхэн үед Оросын цэргийн мэргэжилтэн, түүхчид эхлүүлсэн.

Гэвч ХХ зууны дунд үеэс Чингис хаан, түүний цэргийн түүхийг мушгин гуйвуулах, үзэл суртлын үүднээс зөвхөн нэг талыг баримтлан дүгнэх хандлага газар авч байв. Харин ХХ зууны сүүл үеэс гадаадын олон эрдэмтэн судлаачид түүхэнд бодитой хандахыг эрмэлзэх болсон хэдий ч монгол цэргийн ялалт амжилтыг үгүйсгэх, тэр ч байтугай Чингис хааны үеийн монголчууд өнөөгийн монголчуудтай холбоогүй мэт харуулж, геополитикийн явцуу сонирхлын үүднээс өөрийн улсын түүхтэй санаатайгаар хутган гуйвуулах явдал ч гарах болж байна.

Монголчуудын хувьд ХХ зууны эхнээс түүхч А.Амар “Монголын товч түүх”-дээ цэргийн түүхийн асуудлуудыг хамруулан оруулсан бөгөөд Н.Жадамба 1920-иод оны эхээр “Монголчууд дэлхий дахиныг зэр зэвсгийн хүчээр эзлэн авсан явдлыг ерөнхийлэн шүүмжилсэн нь” хэмээх бүтээл “Улаан цэргийн бодлого” сэтгүүлд хэвлүүлсэн нь цэргийн түүхээр дагнан гарсан анхны нэг сэдэвт зохиол байв.

Социализмын үед Монгол Улсад Чингис хааны цэргийн түүхийг судлах ажил үндсэндээ зогсонги байдалтай, зарим талаар хориотой байсан бөгөөд харин академич Х.Пэрлээ 1942 онд “Монголчуудын цэргийн чадвар”, 1949 онд “Пушкин ба Монголын байлдан дагуулал” өгүүлэл хэвлүүлсэн нь цэргийн түүх бичлэгт түлхэц өгсөн шинэлэг зүйл байлаа.

1970-аад оны сүүлч, 1980-аад он монгол цэргийн түүхийн судлалд эргэлт авчирсан он жилүүд байсан бөгөөд энэ үед академич Ш.Нацагдорж, Ч.Жүгдэр, Н.Ишжамц, Ч.Далай нар монгол цэргийн түүхийн судалгаанд шинэ түлхэц өгсөн бүтээлүүдээ хэвлүүлсэн

билээ. Академич Ш.Нацагдорж 1991 онд хэвлүүлсэн “Чингисийн цадиг” бүтээлдээ Чингис хааны цэргийн түүхийг анх удаа дэлгэрэнгүй оруулсан нь энэ чиглэлийн судалгаанд эрч хүч нэмсэн чухал хувь нэмэр байв.

1990-ээд оны эхнээс Батлан хамгаалах яамны Эрдэм шинжилгээний хүрээлэнгээс Чингис хааны цэргийн түүх судлах ажлыг өргөн хүрээтэй явуулах болсон нь цэргийн түүх судлалын чухал нэг салбар болон хөгжиж байна.

Гэвч сүүлийн үед дээр өгүүлсэнчлэн Чингис хааны цэргийн ялалт амжилтыг үгүйсгэх, гуйвуулах, эс бөгөөс монголчуудын түүхийг өөрийн болгож “хувиргах” хандлага улам бүр газар авч, хүрээгээ тэлэх болж буй нь энэ чиглэлийн судалгааг улам эрчимжүүлэн гүнзгийрүүлэхийг шаардаж байна.

Б.Баярсайхан  
(Монгол улс, ГХЯ)

### **Академич Ш.Нацагдоржийн бүтээлүүд дэх Монголын эрх зүйн түүхийн асуудлууд**

Монголын түүхийн судалгааны үр дүн нь эрх зүйн институцийн хөгжлийн зүй тогтолыг ажиглах, нэгтгэн дүгнэх, харьцуулан судлах боломжийг олгож байдгаараа онцлог юм. Ялангуяа Монголын улс төрийн түүхийн он дарааллын үйл явдал, бодлогын хувьсал, өөрчлөлтийн судалгааны үр дүн нь Монголын эрх зүйн түүхийн судалгааны институцийн болон эрх зүйн сэтгэлгээний уламжлалыг судлах, тэдгээрийн хувьсал өөрчлөлтийг танин мэдэх боломжийг олгож байдаг болно.

Академич Ш.Нацагдоржийн “Цагаан түүхийн тухай”, “Улаан хацарто (Описание памятника)”, “Халхын түүх”, “Монголчуудын өв өвлөх эрх”, “Сум, хамжлага, шавь ард”, “Монголын феодализмын үндсэн замнал”, “Чингис хааны цадиг” зэрэг нэг сэдэвт бүтээлүүдээс гадна, “Богд гэгээний засгийн газрын албан татварын бодлого”, “Мянган, отог, аймгийн тухай” зэрэг эрдэм шинжилгээний өгүүллүүд нь монголын эрх зүйн түүхийн судалгааны ерөнхий асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн түлхэц болсон юм.

Академич Ш.Нацагдоржийн Монгол Улсын эрх зүйн шинжлэх ухааны чиглэлээрх бүтээл туурвилуудыг нэгдүгээрт, монголын эрх зүйн түүх судлалын ерөнхий асуудлаар, хоёрдугаарт, эрх зүйн түүхэн эх сурвалж судлалын чиглэлээр, гуравдугаарт, монголчуудын эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиглэлээр, дөрөвдүгээрт, Монголын эрх зүйн шинжлэх ухааны бусад асуудлаар гэж ангилан авч үзэх ёстой байна.

Д.Баярсайхан  
(Монгол улс, Улаанбаатарын их сургууль)

## **Академич Ш.Нацагдорж ба XVIII-XIX зууны Монголын түүх бичлэг**

Академич Ш.Нацагдорж гуай XVIII-XIX зууны монголын түүх судлалаар голлон ажилласан эрдэмтэн билээ. Түүний тэртээ 1962 онд бичсэн “Халхын түүх” зохиол бол мөнхүү үеийн түүхийн судалгааны гол зохиол мөн болохыг дурьдая. Энэхүү зохиолын зэрэгцээ түүх бичлэгтэй шууд холбогдох “Түүх судлалыг шинэ шатанд гаргая” (1941 он), “Түүх судлалын талаар гүйцэтгэсэн ажил” (1951 он), “Цагаан түүхийн тухай хэдэн үг” (1956 он), “Алтан товчийн зохиогчийн тухай” (1958 он), “Манай түүхийн шинжлэх ухааны зраим ололт” (1959 он), “Улаан хацарт” (1961 он), “То ван ба түүний сургаал” (1969 он), “БНМАУ-ын түүхийн шинжлэх ухаан” (1972 он), “Монголын түүхийн шинжлэх ухааны үндсэн чиглэл” (1978 он), “Халхын Цогт хунтайжийн холбогдолтой нэгэн сурвалж бичигийн тухай” (1980 он) зэрэг олон арван бүтээлийг дурьдаж болно.

Академич Ш.Нацагдорж гуайн судалгааны оргил бүтээл бол “Халхын түүх” билээ. Мөнхүү бүтээлд XVIII-XIX зууны гадаад Монголын түүхийг анхлан шинжлэх ухааны үндэстэйгээр авч судалсан байдаг. Тиймээс бид энэхүү илтгэлд XVIII-XIX зуунд түүх бичлэгийн ухааны хэрхэн хөгжиж байсан тухай өгүүлэхийг зорьлоо.

XVIII-XIX зуунд Монголын түүх бичлэг сайтар хөгжиж түүх бичлэгийн олон арван бүтээл туурвигдан бидний үед уламжлагдан ирж чаджээ. Энэ хоёр зуунд монголын түүх бичлэг ийн хөгжихөд өмнөх үеийн түүх бичлэг тодорхой нөлөөг үзүүлсэн байна. Эдгээр нь, аман түүхийн уламжлал, угийн түүх бичих уламжлал, XVIII зуунаас өмнө зохиогдсон түүхийн зохиолуудын нөлөө байсан бөгөөд тэр дундаа түвэдийн буддын түүх бичлэгийн нөлөө хамгаас их байжээ. Мөн энэ үед Монголчууд Манж Чин гүрний эрхшээлд байсан нь хятад, манжийн түүх бичлэгийн нөлөө тодорхой хэмжээгээр бий болоход хүргэв.

XVII-XIX зууны монголын түүх бичлэгийн бүтээлд төрийн түүхийн сэдэвтэй зохиол тэргүүлэх байрыг эзлэнэ. Тэдгээр зохиолд Монголын түүхийг нэн эртнээс аваад өөрсдийн амьдарч байсан үе хүртэл өгүүлсэн байдаг. Гомбожав “Гангын урсгал” зохиолоо монгол олон аймгийн түүх,

тэдгээрийг захирч байсан ноёдын уг сүлжлийн түүхийг тодорхойлон бичихэд зориулжээ. Ломи гүн Монголын түүхэнд анх удаа боржигин овогтны түүхийг тусгайлан бичив. Дарма гүүш өөрийн зохиолоо үндсэн есөн бүлэгт хуваан бичсэн нь зургаан дэвтрээр бидний үед уламжлагдан иржээ. Мэргэн гэгээн “Алтан товч” зохиолдоо Чингис хааны дүү Хасарын угсааны хүн тул түүний намтар түүхийг 33 бүлэгт хуваан бичсэн тус зохиолдоо тусгайлан бичсэн байна. Рашипунцаг бол Монголын түүх бичлэгт шүүмжлэлт чиглэлийг жинхэнэ утгаар нь бий болгосон түүхч. Тэрээр “Болор эрх” зохиолоо бичихдээ 21 зүйл эх сурвалжийг хооронд нь харьцуулан үзэж, түүхэн хэрэг явдлыг магадлан үзжээ. Галдан туслагчийн “Эрдэнийн эрх” бол умард монголд зохиогдсон, хуулбар болон хувилбар эхээр хамгийн өргөн тархсан, Монголын түүхийг эртнээс нааш XIX зууны дунд үе хүртэл бичиж чадсан түүхийн зохиол юм. Ната “Алтан эрх”-ээ монголын шашны түүхэнд зориулан бичжээ.

“Хөх түүх” бол бусад адилсах зохиолуудын жишгээр шашны түүхийг үүссэн тэр цаг үеэс эхлүүлэн XIX зууны эхэн үе хүртэл бичсэн байхын дээр Далай ламын хувилсан хэдэн үеийн намтрыг тусгайлан бичсэн нь түүх бичлэгийн чухал онцлог болно. Ишбалдан бээр “Эрдэнийн эрх” зохиолоо мөн л шашны түүхэнд зориулан бичжээ. Жамбадоржийн 1835 онд бичсэн “Болор толь” зохиол бол хамгийн өргөн агуулгыг багтаасан, тэр дундаа шашны түүхийг нэлээд дэлгэрэнгүй түлхүү бичсэн зохиол юм. Гүн Гончигжав шашны өндөр мэдлэгтэй нэгэн байсан тул “Сувд эрх” зохиолоо бичихдээ сурвалж эх хэрэглэгдэхүүнийг өргөнөөр харьцуулан хэрэглэж, шашны түүхийг дэлгэрэнгүйгээр бичсэний дээр хятадын түүх бичлэгийн нөлөө нэлээн хүртсэн байна.

XVIII-XIX зууны Монголын түүх бичлэгт орон нутгийн түүх бичлэг тодорхой байрыг эзэлнэ. Энэ үед зохиогдсон орон нутгийн түүхийн зохиол багагүй тоогоор уламжлагджээ. Ойрад, Буриадын түүх, нэгэн аймаг, хошууны түүх бичих хандлага илүү давамгай байв. Тэдгээр зохиолууд нь, тухайн нэгэн бүс нутгийн түүхэнд зориулагдсан, сурвалж эх хэрэглэгдэхүүн бага ашигласан их төлөв зохиогчийн үзэл санааг тусгасан, зохиогчид нь ихэвчлэн тодорхойгүй, зарим зохиолын нэрийдлэгүүд тодорхойгүй гэсэн нийтлэг төрхийг агуулж байна.

Бидний өгүүлэн буй үед холбогдох монгол хэлээр бичигдсэн 20 түүхийн зохиолын 13-ынх нь зохиогч мэдэгдээд байна. Тэдгээр 13 түүхч нь нутаг дэвсгэрийн хувьд, олонхи нь буюу 9 нь Өмнөд



Монголд харьяалагдаж байна. Гончигжав, Ишбалдан нар Ордос аймаг, Жамбадорж, Лувсандамбийжалцан нар Урад аймаг, Гомбованжил Авга аймаг, Рашипунцаг Баарин аймаг, Дарма гүүш Жаруд аймаг, Ломи гүн Харчин аймаг, гүн Гомбожав Үзэмчин аймгийн хүмүүс аж. Дэди Шинжааны, Баатар увш, Гаван Шарав нар нь Халимагийн ойрад хүмүүс байна. Умард Монголын нэгэн түүхч нь Халхын Түшээт хан аймгийн Галдан туслагч юм. Нутаг дэвсгэрийн хувьд ийнхүү ялгаатай байдал нь түүх бичлэгт нөлөө үзүүлж, тэдгээр бүс нутгийн түүхийг түлхүү бичих, түүхийн судалгаа харилцан адилгүй түвшинд орших зэрэг ялгаат байдлыг бий болгожээ.

XVIII-XIX зуунд Монголын түүх бичлэгийн сэдэв агуулга ихээхэн өргөжсөн байна. XVIII зуунаас өмнөх үеийн Монголын түүх бичлэгт тусгайлан оршил бичих явдал байсангүй. Харин энэ үеэс тусгайлан оршил бичиж, түүндээ эхлэлийн шүлэг, түүхээ судлахын чухал, ашигласан эх хэрэглэгдэхүүн, зохиолын бүтэц зэргийг багтаан бичдэг байж. Монгол хаадын гарал угсааг эртний Энэтхэгээс эхлүүлэн Түвэдийн хаадаар дамжуулан улмаар монгол хаадын гарал угсааг өгүүлэх Чакравардын онол энэ үеийн түүх бичлэгт төлөвшин тогтжээ. Шашны түүхийг голлон өгүүлсэн зохиолд гадаад сав, дотоод шим ертөнцийн үүсэл, Чакравардын хаадын тухай нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн байх бол төрийн түүхийг голлон бичсэн зохиолд товчхон байдлаар, харин орон нутгийн түүхийн зохиолд бараг бичээгүй байна.

Намтар түүх бичлэгийн тухайд, Хасар, Жавзандамба хутагт, Амарсанаа нарын намтар үйл хэргийг нэлээд түлхүү бичсэн байна. Мэргэн гэгээн Хасарын угсаа, Галдан туслагч Түшээт хан аймгийн туслагч байсан зэрэг нь тэдний намтар түүхийг бичихэд илүү дөхөм байжээ. Энэ үеийн түүх бичлэгт тусгайлан төгсгөл хэсэг хэмээн зааж бичсэн зүйл таарахгүй боловч бараг бүхий л зохиол төгсгөл хэсэгтэй байна. Энд ашигласан хэрэглэгдэхүүн, хэн бичсэн, хэдэн онд бичсэн, хэн хуулсан, зохиолын нэрийдэл магтаалын шүлэг зэргийг багтаан бичив.

Бидний өгүүлэн буй үед түүхийн судалгааны эх суурь өргөжсөн байна. Энэ нь тэр үеийн түүхчид түүхийн зохиолоо бичихдээ сурвалж хэрэглэгдэхүүнийг өргөн хэрэглэх болсноор илэрнэ. Түүхийн үнэт сурвалж, хэрэглэгдэхүүнийг хэдий сайн ашиглан бичнэ түүхийн зохиол төдий хир чамбай болох аж. Энэ тухай энэхүү илтгэлд тодорхой гарах болно.

У.П.Бичелдей  
(ОХУ, Тувагийн хүмүүнлэгийн болон нийгэм,  
эдийн засгийн хавсарга судалгааны хүрээлэн)

### **Ойун урянхайцы и танды урянхайцы - предки современных тувинцев**

В знаменитой антологии “Урянхай. Тыва дептер”, а также в работах Рашид ад Дина, Сыма Цяна, Марко Поло и других авторов утверждается, что в верховьях Енисея, на котором в настоящее время располагается Республика Тыва - географический Центр Азии, с древних времен проживали лесные урянхайцы - древние предки современных тувинцев.

Тува и сегодня является составной частью единой евразийской цивилизации. Также, как и другие тюрко-монгольские народы Центральной и Внутренней Азии, потомки лесных урянхайцев -тувинцы до сих пор не утратили собственные кочевнические традиции и продолжают обитать на своих исконных территориях.

Название «танды-урянхайцы» закрепилось за предками тувинцев позднее. Данное название определяет место проживания урянхайцев-тувинцев, которое тянется с запада на восток - по северным и южным склонам Тандынского (монг. Тагну) хребта.

Ж.Болдбаатар  
(Монгол улс, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)

## **XX зууны Монголын түүхийн судалгааны тэргүүлэх их эрдэмтэн**

Энэхүү илтгэлд академич Ш.Нацагдоржийн амьдрал, үйл ажиллагааг харьцангуй цогцолбор байдлаар гаргахыг эрмэлзэж, бүтээлүүдийг нь сэдэвчлэн шинжилж, дүгнэлт, гаргалгаа хийн, уран бүтээлийн үйл ажиллагаанд нь цухас боловч дүгнэлт өгч, Монголын түүх судлалд түүний оруулсан хувь нэмрийг аль болох товойлгон үзүүлэхийг зорьсон болно. Мөн түүний эгэл зан, эрхэмсэг чанарыг тодорхойлох оролдлого хийв.

Академич Ш.Нацагдорж бол удам залгасан гурван үеийн сэхээтний төлөөлөгч бөгөөд нүүдэлчдийн нийгэмд тохиолдох ховорхон хувь заяатай хүн юм. Тэр бээр 17 насандаа Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Түүхийн тасагт дагалдан сурагчаар орж, тасгийн эрхлэгч, Түүхийн хүрээлэнгийн захирал, ШУА-ийн дэд ерөнхийлөгчийн албыг нэгэн жарныг давтал хашсан, Монголын түүхийн судалгаанд мөнхийн сац суврага босгосон дэлхийд танигдсан их эрдэмтэн байлаа.

Хэдийгээр түүний бүтээлүүд марксист арга зүйг баримтлан, үзэл суртлын хатуу хяналтын дор бичигдсэн боловч, аль болох аргыг нь олж, түүхэн үнэнийг тогтоох гэсэн шинжлэх ухаанч хандлага давамгайлсан байдаг билээ.

Түүний бүтээлүүдийг хураангуйлан дүгнэвэл:

1. “БНМАУ-ын түүх” нэгэн болон гурван боть, таван боть хамтын бүтээл туурвих ажлыг сэдэн санаачлагч, удирдан зохион байгуулагч төдийгүй олон бүлэг зүйлийг бичихэд голлон оролцсон байна. Учир нь эдгээр бүтээлүүдийг туурвих үед сайхь академич олон арван жил түүхийн судалгааг арга зүйн хувьд түүчээлэн манлайлж, ШУА-ийн Түүхийн хүрээлэнг он удтал удирдаж, нэгэн бүхэл бүтэн үеийн түүхчдийг өөрийн гараар өсгөн хүмүүжүүлсэн тул түүний хуримтлуулсан туршлага, арга барил, дэг сургуулиар голлон бичиж боловсруулсан гэж үзэж болно. Харин “Монгол Улсын түүх” таван боть зохиолыг марксист бус орчин үеийн түүхийн арга зүйгээр бичсэн, энэ үед ч Нацаг багш хэдийнээ асуудалд орчин цагийн арга зүйгээр хандаж,

шавь нартаа энэ чиглэл, үндэслэлээр бичиж, боловсруулахыг заан зөвлөж байсан юм.

2. “Халхын түүх” хэмээх суурь алдарт бүтээлээ туурвиж, Манжийн эрхшээлийн үеийн Монголын засаг захиргааны зохион байгуулалт, нийгэм-ангийн бүтэц, эдийн засгийн амьдралыг цартай судалжээ. Түүхийн цагийн улс төр, үзэл суртлын хэн ч зайлж гарахгүй шаардлагаар ангич байр сууринаас хийсэн гаргалгаа байх боловч түүний бүтээн боловсруулсан энэ түүх нь үеийн үед үнэ цэнэтэй байх нь дамжиггүй.

3. 1978 онд 30 орчим жил явуулсан судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, “Монголын феодализмын үндсэн замнал” суурь бүтээлээ туурвижээ. Эл бүтээлд Монгол оронд хамжлагын харилцаа хэрхэн үүсч, хөгжсөнийг баримт нуттай, өгөөж хаялга сайтай гарган тавьжээ. Эл бүтээл нь Их Монгол улс байгуулагдсанаас ХХ зууны эхний хагас хүртэлх монголын түүхийн үндсэн асуудлуудыг улс төр, нийгмийн харилцааны үүднээс архивын сан хөмрөгөөс дээжлэн шинжлэн дүгнэсэн хамгийн том тулгуур бүтээл юм.

4. Түүний “Монголчуудын өв өвлөх эрх”, “Сум, хамжлага, шавь ард” зэрэг бүтээлүүд нь Монголын дундат зууны үеийн түүхийн амин чухал асуудлуудад ончтой хариу өгсөн юм. Эдгээр бүтээл нь Монгол дундат зууны үеийн нийгмийн бүтэц, ангийн харилцааны толь бичиг мөнөөс мөн.

5. Монголын дундат зууны түүх төдийгүй ойрхи түүхийн үнэнийг эрэлхийлэхэд томоохон үүрэг гүйцэтгэсэн юм. Тэр бээр “МАХН-ын товч түүх”-ийн тэргүүн бүлгийг бичжээ. Түүний санаачилга, удирдлагаар “БНМАУ-ын соёлын түүх”, “Монголын мал аж ахуйн түүх”, “БНМАУ-ын нийгмийн бүтэц”, “Монгол, Зөвлөлтийн харилцааны түүх” зэрэг суурь бүтээлүүдийг зохион нийтлүүлжээ. “БНМАУ-ын соёлын түүх” нь хоёр ботиор хэвлэгдэн гарч, монголчууд ХХ зуунд дундат зууны харанхуй бүдүүлэг байдлаас гарч орчин үеийн соёл иргэншилд дэвшсэн тухай, тухайлбал соёлын байгуулалт хэрхэн өрнөснийг харуулсан байхад “БНМАУ-ын нийгмийн бүтэц” зохиолд ХХ зууны монголын нийгмийн бүтцэд гарсан хувьсал өөрчлөлтийг дүгнэсэн байна.

6. Түүхийг түүхэн хүн судлалын чиглэлтэй болгож, түүхийг эзэнгүйдүүлэх явдлаас зайлсхийх үйлсэд тодорхой хувь нэмэр оруулжээ. Юуны өмнө, “Чингис хааны цадиг” (1991) бүтээл туурвиж, Чингис судлалын салхийг хагалсан юм. Зохиогч эл зохиолоо эртнээс

бодож боловсруулан бичсэн бөгөөд их хааны тухай олон жилийн бодрол, бясалгал нь бийр бэхсийн үзүүрт хуран тунасан нь болой. Мөн “Хубилай сэцэн” (1998) хэмээх бүтээлдээ дэлхий дахины болон Монголын түүхэнд Хубилай хааны гүйцэтгэсэн үүргийг тов тодорхой гаргасан байна. Эдгээр бүтээл нь Чингис, Хубилай хааны талаар монгол түүхчийн бичсэн анхдагч нэгэн сэдэвт зохиолууд байсан юм.

7. “Улаан хацарт”, “То ван түүний сургаал”, “Ардын заргын бичиг”, “Дөрвөн аймгийн алба тэгшитгэсэн данс” (Ц.Насанбалжирын) зэрэг чухал баримт бичгүүдийг боловсруулан нийтлүүлсний дээр “Монгол ардын журамт цэргийн дурдатгалууд дөрвөн боть, “Д.Сүхбаатарын үйл амьдралтай холбогдох баримт материалын эмхтгэл”, “Хувьсгалын өмнөх Монгол дахь газрын харилцаа” гэх зэрэг архивын баримт бичгийн эмхтгэлийг удирдан хийж, хянан нягталж, судалгааны эргэлтэд оруулжээ.

8. Монголын түүхийн сурвалж бичгийн судалгаанд онцгой анхаарал тавьж, “Улаан хацарт”, “Харьяат хошууны дотор дагаж явуулахаар тогтоож тушаасан ухуулах бичгийн уг эх” мэтийн зохиолд оршил удиртгал бичиж, тайлбар зүүлт хийж хэвлүүлж, эргэлтэд оруулж олон нийтийн хүртээл болгожээ. Түүний хорь шахам бүтээл орос, англи, франц, хятад, япон зэрэг хэлнээ орчуулагдан хэвлэгджээ.

9. Монголын их, дээд сургуулиудад багшилж, түүхийн сурах бичиг орчуулах, зохиох ажлыг хийхийн хамт түүхийн салбарын боловсон хүчин бэлтгэхэд анхааран, залуу ажилтнуудыг дагалдуулан сургах, эрдэмтэн бэлтгэхэд биечлэн оролцож ирсэн юм. Ийм учраас Монголын түүхийн бүхэл бүтэн үеийнхний багш нь байлаа.

Академич Ш.Нацагдорж бол Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн хүн байв. 1951 онд Улсын Их Хурлын депутатаар сонгогдож, МАХН-ын хэд хэдэн их хуралд төлөөлөгчөөр оролцож байжээ. Тэрбээр Монголын Энхтайваны хорооны гишүүн, Монгол, Английн найрамдлын нийгэмлэгийн даргаар ажиллаж байлаа.

Сайхь академич 1956 онд Монголын түүхчдийн үндэсний холбоог үүсгэн байгуулалцаж, уг байгууллагын тэргүүнээр хан хорвоогоос халих хүртлээ ажилласан юм.

Академич Ш.Нацагдорж бол Монголын түүхийн билэг төгөлдөр эрдэмтэн, шинжлэх ухааны гарамгай зохион байгуулагч, ХХ зууны монголын түүхчдийн их зонхийн багш, манлай түүхч, нийгмийн нэртэй зүтгэлтэн, авъяаслаг зохиолч хүн байсан билээ.

А.А.Борисов  
(ОХУ, Оросын ШУА-ийн Сибирийн салбарын  
Хүмүүнлэгийн ба Умардын цөөн тоот үндэстний  
судалгааны хүрээлэн)

**Исторический опыт реформирования регионального  
управления на северо-востоке Российской империи  
(на примере Якутии) и в Монголии под власть  
Цин в 1720-е гг.- вторая половина XVIII в.**

К 1728 г. между царской Россией и цинским Китаем была утверждена государственная граница. Среди народов, оказавшихся по обе стороны границы, ведущее место занимали тюркские и монгольские народы. Обе империи приступили к организации управления над ними, которое требовало выработки особых форм осуществления власти.

В России в отношении разных территорий применялось несколько форм: провинциальное воеводство, военно-народное управление, губернии и генерал-губернаторства, а также наместничества окраинных территорий. На северо-востоке страны, где основным населением были тюркоязычные якуты, к изучаемому времени начали применяться первая и третья формы. На местах осуществляли власть вначале ясачные сборщики, затем комиссары. Главы якутских уусов-кланов и улусов – князцы в административном и судебном отношении подчинялись им. На территории Центральной Азии маньчжуры также применяли разные формы подчинения. К тому времени под их властью оказались монголы Внутренней Монголии, наследственные ханы которых непосредственно подчинялись богдыханам. В отношении же монголов Халхи, которые еще не полностью были покорены, была применена форма управления близкая наместничеству.

В налоговой системе царское правительство отдавало предпочтение ясаку, прочие повинности долгое время были гораздо меньшими по объему. Цинское правительство большее внимание уделяло воинской повинности монголов.

После подписания Буринского (1727) и Кяхтинского (1728) договоров возникли условия для укрепления административно-территориального устройства присоединенных земель. По-видимому,

эти процессы не случайно происходили синхронно. Два государства соревновались в поисках более эффективных форм организации власти с целью окончательного закрепления власти, прежде всего над доминировавшими в регионе тюрками и монголами. Якуты управлялись своими *тойонами*, каждый в своем *уусе*-клане, но среди них выдвинулись главные князцы, которые впоследствии возглавили пять якутских *улусов*. У халхасцев помимо *аймаков* были установлены *отогий хошуны*, в которых заметную роль стали играть *чуулганы* – сеймы. Большая власть сосредоточивалась в руках аймачных воевод, назначаемых имперскими властями.

В 1732 г. было создано Улиастайское управление для управления Халхи. После разгрома Джунгарского ханства в 1762 г. было образовано Ховдское управление. По ту сторону границы долгое время существовала уездная система управления с непосредственным подчинением Москве, пока Якутский уезд с 1719 г. не перешел под юрисдикцию Иркутска, который в свою очередь управлялся из Тобольска- центра обширной Сибирской губернии. В 1764 г. возникла самостоятельная Иркутская губерния, а в 1783 г. Якутская провинция была преобразована в особую областную форму управления. В этот период улусная система управления распространилась на западе и севере Якутии

Цинские власти систематически дробили главные административные единицы - *хошуны* (так к 1760 г. их стало 86 против изначальных восьми). Напротив, в Якутии на протяжении изучаемого времени сохранялось единство территории, заселенной якутами. Более того, в 1720-х гг. имело место укрупнение территориально-административных подразделений якутов. Так, вместо 35 “ясачных волостей” Центральной Якутии было образовано пять *улусов*.

И в России и в Цинской империи в этот период придавалось большое значение подготовке управленческих кадров. Довольно интенсивно создавались школы, где обучали писарей для местных органов управления. Периодически из центральных районов империй сюда перемещались для службы чиновники.

Кроме того, управление в Монголии было военизированным, впрочем, как и на землях бурят, хотя и в меньшей степени. В целом, ясачное население Сибири, например, якуты было освобождено от военной службы.

Бүрэнсод  
(БНХАУ, Өвөр Монголын Багшийн их сургууль)

### **Чин улсын үеийн Монголын нийгэм дэх инж дагуулах ёс**

Инж дагуулах явдал нь Чин улсын үеийн Монголын нийгэмд түгээмэл оршиж байсан үзэгдэл юм. Өгүүлэлд, Чин улсын албанаас найруулсан хууль зүйлийн бичгийн ба Өвөр Монголын өөртөө засах орны данс эвхмэлийн газарт хадгалагдаж бүхий Чин улсын үеийн харчин гурван хошууны данс материалд тулгуурлан, тайж тавнангуудын охид харьд мордохдоо инж дагуулж байсан ёс дүрмийн тухай анх алхам туршин өгүүлэв. Инж дагуулах явдал нь үндсэндээ Чин улсын хууль дүрмийн дагуу явагдаж байсан хэрэг боловч хууль дүрэмд тэр бүхнийг тодорхой заасан биш учраас чуулган хошуудын дотооддоо ч зарим дүрэм тогтоол гарган бодтой асуудлыг шийдвэрлэж байсан юм. Үүнд, хамгаас чухал болох нь инж дагуулах хүмүүсийг цөм тайж тавнангуудын өөрсдийнх нь харьяат албат ард буюу тэднүүсийн охидоос олгож байсан бөгөөд энэ нь мөн ч тухайн үеийн Монголын нийгэм дэх ноён албатын харьцааны чухал нэг илрэл байсан явдал болно.



Гэн Чуан  
(БНХАУ, Өвөр Монголын Багшийн их сургууль)

**“Гэрээс эрдмийн сан оршивай” хэмээх  
судрын тухай шинжилгээ**

Илтгэлд “Гэрээс эрдмийн сан оршивай” хэмээх судрын эх ирэлт ба зохиогчийг тодорхойлон өгүүлсэн суурь дээр түүний агуулгыг “Шамба багшийн дэлгэрэнгүй зохиосон төрлийн цадиг нэрт” судрын 105-р зүйлээс 117-р зүйл хүртэлх агуулгатай харьцуулаад анхны шинжилт хийж, хоёр судрын харьцаа холбоо ба ялгааг тодорхойлохыг зорив.

Гэсэр

(Монгол улс, Улаанбаатарын их сургууль)

## **Орочу шигүш, Хутуг шигүш болон Доён Урианхай аймаг**

Монголын түүхийн сурвалж бичгүүдээс үзэхэд, Орочу шигүш болон Хутуг шигүш хоёрын нэг нь Баянмөнх Болох жиноны хадам эцэг, нэг нь Батмөнх даян хааны хадам эцэг болно. Энэ хоёр хүн XV зууны 40-өөд оноос XVI зууны 30-аад он хүртэл тухайн үеийн Монголын улс төрийн тавцанд чухал үүрэг гүйцэтгэж байсан. Хэдийгээр Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Мин улсын талын түүхийн сурвалж бичигт дурдаагүй нарийн зүйлийг тэмдэглэсэн боловч Хутуг шигүш болон Орочу шигүш хоёрын хоорондын харьцаа, харьяаллын талаарх тэмдэглэлийг нь урван хөрвөн, өөр өөрөөр тэмдэглэж ирсэн. Өмнө Орочу шигүш болон Хутаг шигүшийн тухай судалгаа хийсэн эрдэмтдийн судалгаагаар, зарим нь Хутуг шигүшийг Баянмөнх Болох жиноны хадам эцэг гэж үзэж, зарим нь Орочу шигүшийг Баянмөнх Болох жиноны хадам эцэг гэж үзэв. Орочу шигүш болон Хутаг шигүшийн хоёрын аймаг отгийн харьяалалын талаар эрдэмтэн судлаачидын дүгнэлт нь мөн өөр өөр байсан. Зарим нь Урианхай аймгийн гаралтай (Хэнтийн Урианхай) гэдэг, зарим нь Харчин аймгийн гаралтай гэв. Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Орочу шигүш болон Хутуг шигүшийн тухай тэмдэглэл нь өөр өөр байсан боловч Орочу шигүш болон Хутуг шигүш хоёр нь эцэг хүүгийн харьцаатай гэдгийг илэрхийлсэн. Гэтэл хоёр этгээдийн хэн нь эцэг, хэн нь хүү болохыг Хятадын түүхийн сурвалж бичигт холбогдох тэмдэглэлийг харьцуулан судлахгүй бол Орочу шигүшийг эцэг болох нь тогтооход бэрхшээлтэй байсан. Орочу шигүш, Хутаг шигүш хоёрын харьяалал аймгийн тухайд Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Орочу шигүшийг Урууд аймгийн хүн хэмээн тэмдэглэсэн нь их, харин Хутаг шигүшийг Урианхай аймгийн хүн хэмээсэн нь их. Үүний тухай өмнө судалгаа хийсэн эрдэмтэн судлаачид нь Хятадын түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн ташаа мэдээлэлд нөлөөлөгдөн, Орочу шигүш бөгөөд Хутаг шигүш хоёрын харьяалалыг Харчин эсвэл Хэнтийн Урианхай аймаг хэмээв. Бид Орочу шигүш болон Хутуг шигүш хоёрыг эцэг хүү

хоёрын харьцаатайг тогтоосон болохоор хоёр этгээдийг бүгд Урианхай аймгийн ноёдын гаралтай байх нь тодорхой. Тэгвэл бидний ерөнхий ойлголтоор тухайн үед “Хэнтийн Урианхай” болон “Доён Урианхай” хэмээх хоёр Урианхай аймаг байсан бол, Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Урианхай аймгийн хэмээх түүхийн баатрууд нь яг хэн нь аль “Урианхай” аймгийн хүн болохыг нарийвчлан тэмдэглээгүй. Тиймээс Монголын түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн Орочу шигүшийн ноёлж байсан Урууд аймгийн тухай хянаваас Доён Урианхай аймагт харьяалагдаж байсан болно.

Тэгвэл Орочу шигүш Доён Урианхай аймагтай яг ямар холбоотой байхыг хянавал, хэдийгээр Хятадын Мин улсын түүхийн сурвалж бичигт Доён Урианхай аймгийн ноёдын нэгнийг Аа Ар Чи Ман хэмээн тэмдэглэсэн боловч, Монголын түүхийн сурвалж бичигт Орочу шигүш хэмээн тэмдэглэсэн байв. Үүнийг харьцуулбал тэд нарын харьяалал, түүхийн үйл ажиллагааг холбож үзвэл нэг хүн болно. Доён Урианхай аймгийн ноёдын их хаантай тогтоосон ургийн холбооноос үзвэл Мин улсын түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн Аа Ар Чи Маны хөвгүүн Хуа Дан, Манж Чин улсын “Илтгэл шастир”-д тэмдэглэсэн Хотун бол Монголын сурвалж бичигт тэмдэглэсэн Хутуг шигүш болно.

Дараахүү  
(БНХАУ, ӨМ ӨЗО-ны Засаг захиргааны дээд сургууль)

## **Хаант Оросын төмөр зам хийгээд Ганжуур сүмийн зах арилжаа**

Ганжуур сүм бол Хөлөнбуйрын хамгийн том бурхан шашны сүм хийд болохоор үл барам тухайн газар орны хамгийн том арилжаа худалдааны төв байсан юм. Гэтэл 1896-1935 оны хооронд Хаант (Зөвлөлт) Орос улсын дэвсч эзэгнэсэн төмөр зам (Сибирийн их төмөр замын нэг хэсэг) Хөлөнбуйрын монгол хошуудаар дайран өнгөрөхийг дагалдан, Ганжуур сүм нь арилжаа худалдааны голлох байр сууриа аажмаар алдаж, харин Хайлар, Манжуур зэрэг төмөр замын өртөөнүүдээр хүйс болгон бүрэлдсэн шинэ хот балгасны арилжаа худалдаагаар орлогдсон байдаг.

Тус өгүүлэлд, төмөр зам хийгээд арилжаа худалдааны уялдлын хараанаас Ганжуур сүмийн зах арилжааны хөгжилт хувиралт лугаа холбогдох Хөлөнбуйр орны нийгмийн улиралт хувьсалтыг доорх гурван талаар задлан өгүүлэв.

Эн түрүүнд, анхны үеийн Ганжуур сүмийн зах арилжааны хөгжөөнт байдлын тухай, Ганжуур сүмийн их арилжааны бүрэлдэл, жил бүр нээгдэх цаг хугацаа ба хөгжөөнт байдал, ар өвөр монголчууд хийгээд орос, хятад худалдаачдын хоорондох солилцооны хэлбэр маяг, борлуулах бараа таваарын төрөл зүйл ба үнэ ханш, Ганжуур сүмийн зах арилжааны худалдаан нормын нэмэгдэл хорогдлын байдал зэргийг нягтлан танилцуулав.

Дараа нь, төмөр зам нэвтэрсний дараах Ганжуур сүмийн зах арилжааны хувиралтын тухай, оросчуудын Хөлөнбуйр орон дахь арилжаа худалдаан онц эрх, Хайлар Манжуурын арилжаа худалдааны цагираг, төмөр замаар оруулж гаргасан эд бараа, орос зоос өргөнөөр хэрэглэгдсэн, мал алж нядлах газар ба арьс ноос угааж цэвэрлэх үйлдвэр буй болсон зэрэг агуулгаар нарийн задлалт хийв.

Дахьвал, Ганжуур сүмийн зах арилжааны адил бус цаг үеийн нөлөө тусгалын тухай, төмөр замын харилцааны нөлөөлөл дорх Хөлөнбуйрын арилжаа худалдааны хүрээ хэвчээ, мал аж ахуйн бүтэц, гадаад харилцаа зэрэг талаар янз бүрийн хувиралт гарсан тухай задлан тоочив.

П.Дэлгэржаргал  
(Монгол улс, МУИС)

## **Дундад эртний Монголчуудын нийгмийн байгууллын судалгаанд академич Ш.Нацагдоржийн оруулсан хувь нэмэр**

Академич Ш.Нацагдоржийн “Монголын феодализмын үндсэн замнал” (1978) зэрэг нэгэн сэдэвт бүтээл болон “Мянган, отог, аймгийн тухай” (1970) зэрэг өгүүлүүд нь дундад зууны Монголчуудын нийгмийн байгууллын судалгаанд үлэмж хувь нэмэр оруулж, тухайн үеийн судалгааг нэгэн шат ахиулсан суурь судалгааны бүтээлүүд билээ. Түүний “Монголын феодализмын үндсэн замнал” зохиол нь Монголд феодализм хэрхэн үүсч, хөгжиж, задарсан асуудлыг бүхэлд нь нэгтгэн дүгнэхийг зорьсон, дундад үеийн монголчуудын нийгмийн байгууллын үндсэн асуудлуудыг нэгтгэн дүгнэсэн суурь судалгааны онцгой бүтээл юм. Тэрээр зохиолын оршилд “Би энэхүү “Монголын феодализмын үндсэн замнал” гэдэг зохиолдоо Монголын феодалын түүхийг судлах талаар 30 орчим жилийн дотор хийсэн ажлаа дүгнэхийг оролдлоо” хэмээн бичсэн байдаг. Монголын феодализмын үүслийг зөвхөн XIII зууны үеэс огцом авч үзэлгүй харин монгол дахь эртний төр улсуудын дунд феодалын харилцаа ямар нэг хэмжээгээр үүсэн бүрэлдэж байсны зүй ёсны үргэлжлэл бөгөөд тэгэхдээ нүүдлийн мал аж ахуйн үндсэн дээр бие дааж хөгжсөн тэрхүү онцлогийг тодруулахад гол анхаарлаа хандуулжээ. Дундад эртний нүүдэлчдийн мал ба бэлчээрийн харилцааг бүхэлд нь нарийвчлан шинжилж, нүүдэлчдийн хувьд газар ба мал нь үйлдвэрлэлийн хэрэгслийн үндсэн үүргийг адилхан гүйцэтгэдэг гэсэн шинэ дүгнэлтэнд хүрсэн байна. Түүнчлэн монголын улс төрийн бүтэц нь овог аймгийн байгууллаас феодалын төр болтлоо хувьсан хөгжсөн асуудал, анги бүрэлдэх үйл явц, нийгмийн бүтэц, давхраажил, түүний дотор нүүдлийн мал аж ахуйг хүрээ ба айлаар хөтлөн явуулах хэлбэр, газар өмчлөлийн хэлбэрүүд, Монголчуудын засаг захиргааны үндсэн нэгж мянган, отог, аймаг, хошууны үүсэл, хөгжил, залгамж холбооны асуудал зэрэг нийгмийн байгууллын үндсэн гол асуудлыг нарийвчлан судалж, нэгтгэн дүгнэсэн байна.

А.Жамбал  
(Монгол улс, “Тэнгэр” дээд сургууль)

### **Академич Ш.Нацагдорж Монголын нийгэм-улс төр, эрхийн сэтгэлгээний түүхийг судалсан нь**

Монголын нийгэм-улс төр, эрхийн сэтгэлгээ нь баялаг агуулгатай, олон зуун жилийн түүхэн уламжлалтай бөгөөд түүнийг судлан боловсруулах явдал онол, танин мэдэхүйн болон сургалт боловсролын практикт ихээхэн ач холбогдолтой болно. Түүнийг холбогдох эх сурвалж, баттай мэдээ баримтын үндсэн дээр шинжлэх ухаанчаар судлах ажил 1950- иад оны эхэн үеэс академич Ш.Нацагдоржийн үүсгэл санаачилга, бүтээл туурвилаар эхэлжээ.

Академич Ш.Нацагдорж “Монголын нууц товчоо”-г 1940-өөд оны сүүлчээр, “Цагаан түүх”, “Улаан хацарт”, “Халх журам”-ыг 1950-иад онд, То вангийн сургаалыг 1960 - аад онд, улмаар Чингис, Хувилай хааны нийгэм улс төрийн үзэл санааг 1980-1990 – ээд онд судалж, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, нэгэн сэдэвт бүтээл зэрэг төрөл зүйл бүхий ном зохиолдоо бичиж тусгажээ.

Академич Ш.Нацагдорж монголын нийгэм - улс төр, эрхийн сэтгэлгээний нэлээд асуудлыг “Ар Монголд гарсан ардын хөдөлгөөн” (1956 он), “Халхын түүх” (1963 он), “Сум, хамжлага, шавь ард” (1972 он), “Монголын феодализмын үндсэн замнал” (1978) бүтээлдээ ч зохих хэмжээгээр авч үзэж өөрийн үзэл санаа, үнэлэлт дүгнэлтээ дэвшүүлэн тавьсан байна.

Тус илтгэлд академич Ш.Нацагдорж Монголын нийгэм-улс төр, эрхийн сэтгэлгээний түүхийг дээр дурдсан болон бусад бүтээлдээ хэрхэн шинжлэн судлаж ямар үзэл санаа, үнэлэлт дүгнэлт дэвшүүлэн тавьсныг авч үзсэн болно.

Г.Жигжидсүрэн  
(Монгол улс)

## **Шагдаржавын Нацагдорж - кино зохиолч**

Утга зохиолын төрлүүд дотроос хамгийн адармаатай нь кино зохиол.

Уран зохиолыг уншихад зориулж бичдэг бол кино зохиолыг үзэхэд зориулж туурвидаг. Ямар ч кино зохиол эх хувиараа дэлгэцэнд амилна гэж үгүй. Эндээс үүдэн кино зохиолыг зориглон оролдох хүн цөөн. Үзэгчдэд зориулж зохиол бичнэ гэдэг дэлгэцэнд гарах бүх юмыг тоочин нуршихын нэр биш. Энд зохиолчийн онцгой мэдрэмж, зохиолын үйл явдлын өрнөлийг хэрхэн зохиомжлохоос эхлээд дүрүүдийн зан төрхийн илрэлийг яаж тусгах, эцэст нь зохиолынхоо гол утга агуулгыг хэрхэн тодруулж гаргах зэрэг ур чадвар илэрдэг. Кино-зохиол өөрийн гэсэн өвөрмөц хэллэгийг шаарддаг. Энэ бүхнийг мэдэрч байж кино-зохиолыг бичдэг. Хүн бүхэн, зохиолч бүхэн кино зохиолыг дагнан оролдох нь ховор. Ялангуяа Монголын кино урлагт кино - зохиолоор мэргэшсэн зохиолчид цөөн. Тэдний дотроос энэ төрөлд нилээд гаршсан, авьяаслаг кино зохиолчийн нэг нь манай нэрт түүхч, академич Шагдаржавын Нацагдорж асан билээ. Тэрбээр бүрэн хэмжээний уран сайхны киноны 6 зохиол бичсэнээс “Ичээнд нь” кино 1972 онд “Мандхай цэцэн хатан” 1988 онд тус тус дэлгэцнээ гарсан юм. Түүний туурвисан кино-зохиолууд нь бүгд түүхэн сэдэвтэй бөгөөд Монголын түүхийн нилээд ээдрээтэй, эгзэгтэй гол гол үеүдийн тусгал, тэндээс төрж гарсан түүхэн бие хүмүүсийн дүр төрхийг өөрийн өнцгөөс сонирхолтойгоор бүтээн амьдруулсан байдаг. Энд Ш.Нацагдорж гуайн кино-зохиолуудыг уншихад түүхч хүний ул суурьтай судалгаа, тэндээс үүдэн гарсан нарийн шинжилгээ дүгнэлтүүд илт мэдрэгддэг. Түүний бичиж үлдээсэн кино зохиолууд “Ононгийн цалгиа”, “Ван Жао гүнж” зэрэг нь өнөөдөр эргэн харахад Монголын кино зохиолын сан хөмрөгт тод томруун хэвээрээ байна. Эдгээр зохиолуудаар кино бүтээхэд хөрөнгө мөнгөний гачигдал байгаа гэдэг нь хэн бүхэнд тодорхой буй заа. Ингээд энэхүү товч илтгэлд дээр дурьдсан 2 кино болон бусад зохиолуудын нь онцлогийн талаар өөрийн ажиглалтыг Та бүхэнд толилуулъя. Ш.Нацагдорж гуайн кино зохиолуудаас ур чадварын хувьд сонирхол татаж буй хэсгүүдээс ярина.

Э.Жигмэддорж  
(Монгол улс, МУИС)

## **“Халхын үйсэн цааз” дахь XVI-XVII зууны Монголын түүхэнд холбогдох зарим мэдээ**

Монгол улсын Дашинчилэн сумын нутаг дахь Хар бухын балгасны гол суварганы тууриас олдсон 1000 гаруй үйсэн бичгийн дурсгалын доторхи нэгэн сонирхолтой хэсэг нь Халхын үйсэн цааз болой.

Халхын үйсэн цааз бол XVI зууны сүүл XVII зууны тэргүүн хагасын Монголын түүх, хууль цааз, аж ахуй, соёл, шүтлэг бишрэл, уран зохиолыг судлах бичгийн сурвалжийн нэг юм. Халхын үйсэн цаазын үндсэн эх өнөөг хүртэл хэвлэгдээгүй бөгөөд судлаачид Х.Пэрлээ гуайн хэвлүүлсэн гар хуулбарыг баримтлан судалгаа хийж, бүтээлдээ ашигласаар ирсэн юм.

Бидний судалгаагаар “Халхын үйсэн цааз”-ын агуулга нь:

1. XVI зууны сүүлчээс XVII зууны дунд үе хүртэл Халхын язгууртан ноёдын арван найман удаагийн чуулганаар хэлэлцэн тогтоосон цааз,
2. “Зургаан түмний их түгэлийн бичиг” буюу Чингис хааны 9 өрлөгийн магтаал гэсэн хоёр хэсгээс бүрдэж байна.

Энэхүү илтгэлд “Халхын үйсэн цааз”-ын эх бичгийн онцлог болон уг сурвалж дахь XVI-XVII зууны Монголын түүхэнд холбогдох зарим мэдээ баримтын талаар товч өгүүлэхийг зорив.



Ли Чунмэй  
(БНХАУ, Өвөр Монголын  
Нийгмийн Шинжлэх ухааны хүрээлэн)

## **On the nature of Chan Yu's power**

In view of academic opinions on the discordant nature of the Huns in the nature of power, relying on analysis the position of the Noble Conference which is the important institution of Chan Yu Ting and its relationship with Chan Yu, and this paper will draw a conclusion on the nature of Chan Yu's power. At the time of Touman, from the few important events that have been recorded, whether it is the inheritance of the highest power's issue or the launch of war on the Rou Zhi, Touman basically dominated everything within and outside the regime. There were no signs of the participation or inhibition of the collective power organs or ministers. It had reflected the authoritarian tendencies of power. At the time of Modu, frequent campaigns and a series of victories had exacerbated the autocratic nature of power alone, and the single highest rule position had been completely established. From this point of view, we suppose that the noble conference had a certain power and it also had certain influence on the decision-making, however, there was no role of restraining or restricting the power of the individual and it were completely subservient to Chan Yu's will. According to this opinion, the paper tends to the view that Chan Yu's power had autocratic nature. The concrete embodiment of the Chan Yu autocratic power is as follows: the hereditary system of Chan Yu is fully established, and the throne position was limited to generations within the royal blood; strengthening and consolidating Chan Yu's power by theocratic authority; Chan Yu is the supreme owner of the territory of Huns, who grasped and governed all the property and resources in the field; Chan Yu established a set of management systems and institutions for its control the subjects and the land, the handling of various military and administrative affairs; Chan Yu firmly grasped the power of minister's promotion, demotion and replacement, and the final judicial authority; Chan Yu controls the power of the local army. Therefore, the power of Chan Yu is far more than the power owned by a tribal leader or the head of the early state, and it is an autocratic monarch with the highest decision-making powers, such as executive power, military affairs, financial power, the judicial Power.

Ш.Мөнхбаатар  
(Монгол улс, МУБИС)

### **Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны гурван нутгийн зургийн тухай**

Erdene zasag banner of Khalkha's Tusheet khan aimag was established in 1694, existed for 237 years and dissolved in 1931. There are 5 distinct maps of the territory of Tusheet zasag banner and 3 of them were created in 1907, 1922 and 1930. These three maps are stored in the National library of Mongolia. Some objects are drawn as they appear to us in realistic forms and therefore it is easy to understand what kind of objects they represent. Boundary lines and relay stations are drawn in red or black, but except for these, unpaved roads are drawn in yellow, rivers and lakes in blue color and grassland and forests in green.

Б.Мөнхбаяр

(Монгол улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн)

### Зохиолч Ш.Нацагдорж

Монгол Улсын Төрийн хошой шагналт, эрдэмтэн зохиолч Шагдаржавын Нацагдорж бол ХХ зууны монгол роман бичлэгийн туурвил зүйн сэтгэлгээнд, монгол романы түүхэн төрөл зүйлийн хөгжилд үнэт хувь нэмэр оруулсан зохиолчийн нэг юм.

Түүний романы гол шинж нь *ямар нэг ул үндэсгүй зохиомол хэрэг явдал юм уу, худал түүхийг огтхон ч оруулалгүй, ... гагцхүү үнэнд шүтэж, үнэн магадтайг* үзүүлж ирсэнд оршино.

Ш.Нацагдорж гуайн уран бүтээлийн үндсэн зорилго нь Монгол Улсынхаа түүхийг уран зохиол, уран дүрээр дүрслэн өгүүлэхэд оршиж байв. Тэрээр:

- Их Монгол улс, Чингис хааны түүхийг: “Чингис хааны цадиг”-аараа;
- Монголчуудын хагарал бутрал, дундад эртний үеийн зөрчилт тэмцлийн түүхийг: “Мандхай Цэцэн”-ээрээ;
- XVI-XVII зууны үеийн Монгол орны нийгэм улс төрийн байдал, түүхэн цаг үеийн нөхцөл, гадаад дотоод уур амьсгал орчин тойрны тухай “Алтан хан”-аараа;
- XVIII зуун, Манжийн эсрэг тэмцсэн баатарлаг эх орончдын түүхийг “Болор толь”-оороо үзүүлж,

монголчуудын ялан дийлсэн, сөхрөн сүйдсэн, ерөөс Монгол үндэстний өвөг дээдсийн туулж өнгөрүүлсэн баатарлаг тэмцлийн жинхэнэ мөн чанар, утга учир, хожим хойчийн ач холбогдол, туршлага, сургамж гээд чухам монголчуудын “National Identity” буюу “Үндэсний өвөр төрх”-ийг бүрэн зураглаж харуулж чадсанд л Ш.Нацагдорж гуайн ХХ зууны монгол уран зохиолын туурвил зүйн сэтгэлгээ, роман бичлэгт оруулсан хувь нэмэр нь тодорхойлогдоно.

Үүнээс гадна Ш.Нацагдорж гуай бол шинэ цагийн Монголын зохиолчдын байгууллагын хүндэт зүтгэлтдийн нэгэн байсан билээ.

Б.З.Нанзатов  
(ОХУ, Оросын ШУА-ийн Сибирийн салбарын  
Монгол, төвд, буддын судлалын хүрээлэн)

### **Степные думы-органы самоуправления бурят Российской империи в XIX в.**

Бурятские степные думы представляют собой один из вариантов имперского управления национальными окраинами на восточных рубежах Российской империи. Бурятские степные думы стали преемницами первых национальных органов самоуправления бурят; “мирских сборных изб”, степных контор, которые возглавили ведомства, созданные на основе бурятских “поколений” (родовых и племенных образований). Административное устройство степных дум, особенности их функционирования отражают этапы адаптации и дальнейшей интеграции бурят в российское общество, опыт выстраивания системы отношений центра и периферии, региональные особенности управления национальными территориями. Специфика имперского управления в Забайкалье определялась также и приграничным положением бурятских территорий.

Накамүра Ацүши  
(Япон, Ямагата их сургууль)

## **Манжийн үеийн өртөө ба Халхын нийгэм: Сайр ус өртөөний жишээн дээр**

Манжийн үед монголчуудыг хошуунаас гарч нүүхийг хориглох хуультай байсны улмаас, Манжийн засаг захиргаанаас монголчуудын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, хошуун дотор хорьсон мэт ойлголт түгээмэл байдаг.

Гэтэл Манжийн захиргаанаас жил бүр тогтсон тоо, тогтсон хугацаа, тогтсон журмаар монголчууд хошуунаасаа гарч, шилжилт хөдөлгөөн хийх тогтолцоо буй болгосон билээ. Энэ нь юу вэ гэвэл, олон зүйлийн алба болно. Түүний дотор, хамгийн олон хүн, удаан хугацаагаар алс хол газар явдаг албаны нэг нь өртөөний алба болно.

Өртөөний алба хэдий хүнд хэцүү алба байсан авч, өртөө нь тухайн үеийн хүний болон мэдээлэлийн шилжилт хөдөлгөөний тулгуур болох нийгмийн дэд бүтэц байв. Манжийн сайд түшмэдээс гадна олон монголчууд төдийгүй орос, хятадын худалдаачид өртөөгөөр явж байсан тул өртөөг хүн хийгээд мэдээллийг холбож байсан зангилаа газар гэж үзэж болох юм.

Эл илтгэлд, Халх дахь өртөөний том зангилаа газар байсан Сайр усны өртөөгөөр жишээ болгон, Харчин өртөөний захиргааны тогтолцоо, хүний шилжилт хөдөлгөөн, өртөөний байдлыг тодруулж, улмаар Халхын нийгэм дэх өртөөний ач холбогдлыг авч үзнэ.

Насан-Өлзий  
(БНХАУ, Өвөр Монголын Багшийн их сургууль)

**Дайчин гүрний үе дэх Монголын нийгмийн  
“Дарханы дүрэм”-ийн судлал  
(Тайцзун хаанаас Найралт Төв хааны үе хүртэл)**

Дайчин улсаас Монголын нийгэмд хэрэгжүүлж байсан олон дүрэм байгууллуудын нэг нь дархны дүрэм юм. Одоо мэдэж байгаагаар Төв Азийн нүүдэлчдийн дотор хамгийн эрт дархны дүрэм хэрэглэж байсан нь жоужаньчууд. Түрэг, уйгурууд уул дүрмийг уламжлан хэрэглэж байв. Монголчууд XIII зуунаас XVII-XVIII зуун хүртэл уул дүрмийг хэрэглэж байсан нь түүхэн бичиг болон хууль цаазын бичгүүдэд тодорхой тэмдэглэгдэж байна.

Дайчин улсын “Хууль зүйлийн бичиг” болон “Хуй дянь” бичигт хэдийгээр дархны дүрмийн тухай зүйл заалт буюу тогтоол бичигдэж байв, үүнээс энэхүү дүрэм байгууллыг тодорхой гүйцэд олж харахгүй мөртөө бодтой хэрэгжиж байсан байдлыг нэн ч мэдэж чадахгүй.

Харин “Чин улсын дотоод нарийн бичгийн яамны монгол данс”, “Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс”, “Дайчин гүрний эхэн үеийн Гадаад Монголын төрийг засах явдлын яамны манж монгол айлтгалын дэвтрүүд” зэрэг данс сурвалжид тэмдэглэгдсэн дархны тухай сурвалж тэмдэглэл, монголчуудын хэрэгжүүлж байсан дархны дүрэм байгуулал, “Хууль зүйлийн бичиг” болон “Хуй дянь” бичиг дэх дархны тухай зүйл заалт болон тогтоолыг харгуулан шинжилбэл Дайчин улс нь монголчуудын дархны дүрмийг уламжлан авч, XVII-XVIII зууны Монголын нийгэмд дархны дүрмийг өргөнөөр хэрэгжүүлж байсныг тодлон таних боломжтой.

Эл өгүүлэлд дархны дүрмийг хэрэглэсэн цаг хугацаа ба хүрээ хэвчээ, дархан цол ба дархны тэмдэг бичиг, дархны зэрэг дэс ба дархны үе залгамжлал, дархлах нөхцөл ба дархны онц эрх зэрэг бодтой хэрэгжсэн байдлыг тодорхойлж, энэ суурин дээр улмаар энэ дүрмийн ач холбогдол болон байр суурийг шинжлэв.

Б.Нацагдорж  
(Монгол улс, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)

**The historical memory of the Mongols during  
the Qing period**  
(*On the example of the Mongol nobles' correspondence*)

After the death of last Great khan Ligden Khutugtu, Mongol nobles from the southern side of Gobi gathered together in 1636 to recognize Manchu ruler Hongtaiji as their legitimate khan. Within century and half, almost all the remaining Mongols were incorporated into the Manchu Qing Empire, as some others were conquered and incorporated into Russia. Thus, by 1770s all the Mongols were living either under the rule of Manchu Qing emperor or the Russian Tsar. Both Manchus and Russians were once subjected peoples of the Mongol Empire. So, in this short report I tried to describe, how the Mongol nobles were seeing their new masters and the relationship with them.

Ока Ильди́ко  
(Япон улс, Тохокү их сургууль)

## **The Heritage of the Clothing of the Great Mongol Empire and its Influence on the Clothing of the Mongols: The Coats with Horizontal Cross-partition**

It is common knowledge that the coat of the Mongolian lamas has preserved some basic features of the archaic Mongol costume. Based on recent discoveries of archaeological textiles from the 14 th century, now we can identify another survival of the clothing of the Mongol, more exactly the Yuan Empire. At the end of the 13 th century, the imperial textile manufactures began to produce a new type of “Mongol” coat, which became very fashionable during the 14 th century. It had a horizontal cross-partition on the waist, and its skirt was gathered in narrow - or in some cases wider - plaits. After the collapse of the Yuan, latter type of this garment was incorporated into the official clothing of the Ming and later the Qing Dynasty. We can't be sure, that this coat completely disappeared from their clothing, but so far there is no archaeological evidence of its survival from Mongolia. Later, when the Mongol Khanates became the part of the Qing Empire, the official clothing of the Mongol nobles had to follow the Manchu dress regulations, and unbeknown to them, they borrowed back this garment. This type of garment, and its several variations, became widely popular not only in the territory of the Qing Empire, but among the Buryats and the other nationalities of Siberia. When discussing the clothing cultures of these people, we have to recognize these similarities and try to find the possible reason behind them.



Ока Хироки  
(Япон улс, Тохокү их сургууль)

## **Манжийн үеийн Монголд Манжийн хууль эс хэрэгжсэний учир**

Манж чингийн төр Монголын аймаг хошуудыг захирах зорилгоор Монгол цаазын бичиг зэрэг тусгай хууль бичгийг эмхтгэн тархааж, засаг захиргаа, ёслол, эрүүгийн зэрэг албан хэргийг шийтгэн захирахад удирдамж болгон хэрэглэж байжээ. Бас Жавзандамба хутагтын шавьд “Халх журам”, “Улаан хацарт” зэрэг орон нутгийн хуулийг зэрэгцэн хэрэглэж байсныг судлаачид нэгэнт тодруулжээ.

Тухайн үеийн Монгол дахь хуулийн үйлчилгээний асуудлыг судлахдаа, эдгээр хуулиуд жинхэнэ амьдралд хэр зэрэг хэрэгжиж байсан бэ гэдэг асуудлыг ч судлаачид анхааралдаа авч хууль зүйн үүднээс судалгаа хийсэн байна. Харин хуулийн хэрэгжилтийн асуудал нь орон нутгийн хууль тогтоомжийн асуудал байдгийн зэрэгцээ, хуулийг баримталж байсан эсвэл үл баримталж байсан тухайн нутгийн оршин суугчдын нийгмийн бодит харилцаагаар шалтгаалан тодорхойлогдох тал байна гэдгийг үгүйсгэхийн аргагүй. Өөрөөр хэлбэл орон нутгийн хэмжээнд Чингийн хуулийг баримтлах ёстой гэдгийг мэдсээр атал, дур мэдэн өөрөө шийтгэх явдал байсан юм.

Тиймээс бид энэ илтгэлдээ, Чингийн хууль хэрэгжилтийн асуудлыг хууль зүйн үүднээс бус, харин нийгмийн харилцааны үүднээс авч үзэн, бодит жишээн дээр судлахыг оролдов. Үүнд “Дайчин гүрний эхэн үеийн Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны манж монгол айлтгалын дэвтэрүүд” эмхтгэлд орсон малын хулгайн хэргийг шийтгэсэн тухай айлтгалын дотроос, Тэнгэрийн тэтгэсний үед манжийн хуулийн зарчмыг зөрчиж, хошууны дотор эчнээгээр шийтгэсэн хэргийг жишээ болгон авч үзэв.

Үүнд, Тэнгэрийн тэтгэсний 32-р онд Жирэмийн чуулганы Горлос хойт хошуунд гарсан нэгэн хулгайн хэргээр жишээлж, хулгайн хэргийг эчнээгээр шийтгэхдээ нутгийн ардуудын нийгмийн харилцаа нөлөөлж байсан тухай дурьдах болно.

А.Пунсаг

(Монгол улс, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)

### **Академич Ш.Нацагдорж ба дундад зууны Монголын түүхийн судалгаа**

Академич Ш.Нацагдорж бол Монголын дундад зууны үеийн түүх, улс төр, эдийн засаг, нийгмийн байгуулал, ёс заншил, сурвалж бичиг, түүхт хүмүүс зэрэг өргөн дэлгэр цар хүрээтэй судалгаа хийсэн томоохон эрдэмтний нэг нь билээ. Түүний зохиол бүтээлийг ажиглахад цагийн өнгө аясыг дагаж зүсээ хувиргасан зүйл байхгүй, харин түүхэн үнэнийг баримталж төв шудрагаар Монголын түүхийн ноён нурууг түшсэнээрээ зарим хүмүүсийн бүтээлээс илт ялгарч номын хөшөө болон сүндэрлэн өвлөгдөж байна.

#### *Нэг. Монголын эзэнт гүрний тухай судалгаа*

Чингис хаан болон түүний залгамжлагчдын байлдан дагуулах, засан тохинуулах үйл ажиллагааны үр дүнд Алтан ордны улс, Ил хаант улс, Цагаадайн улс, Монголын Юань улс гэх мэт Монголын эзэнт улсууд бүрэлдэн тогтносон билээ. Академич Ш.Нацагдорж гуай Монголын эзэнт гүрний талаар бас чамгүй судалгаа хийсэн бөгөөд бичсэн зохиолууддаа эзэнт гүрний бүрэлдэн тогтсон үйл явц, эзэлсэн газар нутаг, дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг нөлөө зэрэг талаар сонирхолтой гаргалгаа дүгнэлт хийсэн байдаг. Энд зөвхөн “Хубилай сэцэн хаан” гэдэг зохиолоор нь жишээлэн өгүүлье. Уг зохиол нь голдуу Хубилай сэцэн хааны үйл явдлыг үнэлэхэд чиглэгдсэн гэх боловч Монголын Юань улсын үүсэл бүрэлдэл, түүний түүхэн байр суурь, Монгол болон дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн ач холбогдол зэрэг талыг ч тодруулан өгүүлсэн байна. Тухайлбал, “Хубилай бол Чингисийн дараа түүний үйл хэргийг шинэ нөхцөл байдалд нэр төртэй гарамгай залгамжлагч” мөн болохыг тэмдэглээд “Хубилай нүүдэлчдийн тэргүүн нарын дотроос Хятад орныг анх удаа нэгтгэн захирсан, Хятадын “их гэр бүл” гэгчийг буй болгосон, 300 илүү жил Хятад орон Умард, Өмнө хэмээн хуваагдмал байсныг Хубилай анх удаа нэгдмэл болгосноор Хятадын түүхчид Хятадын олон үндэстний улс хэмээн нэрлэдэг. Энэ нь үнэний хувьтай. Харин Хятад хэдийгээс олон үндэстэнтэй нэгдмэл орон болсон гэдгийг нягтлан үзүүштэй. Миний бодоход чухамхүү

Юань улсын үед Хубилайн төр барьсан тэр цагаас нэгдмэл улсын шинж төрхийг бүрэн дүүрэн олсон болов уу. Чухамхүү тийм ч учраас Хятадын түүхчид Юань улсын үеийг аугаа их нэгдмэл үе хэмээн нэрлэсэн байна. Хубилай Хятад орныг захиран төр барьсан хугацаанд Хятад бол дэлхийн хамгийн том гүрэн болон хувирсан. Юань улсын ноёрхол нь Хятадын эдийн засаг, соёлын хөгжилд шинэ түлхэц өгсөн. Хубилайн байгуулсан Их Юань улсын ноёрхлын үед өрнө дорнын хоорондын холбоо харилцаа үүсэн хөгжсөн билээ” хэмээн дүгнэн бичжээ. Мөн түүнчлэн “Хубилай нүүдэл суурьшлыг тохижуулах, тэдгээрийн тэнцвэрийг олох, чингэхдээ Монголыг монгол хэвээр нь үлдэхийг чармайж Монголын соёл иргэншлийг уусан хайлахаас аварсан, ... Хубилай бол Төв Азийн байтугай дэлхий дахины түүхэнд асар том үүрэг гүйцэтгэсэн болох нь ямар ч эргэлзээгүй” хэмээн Монголын Юань улс болон Хубилай сэцэн хааны тухай голыг нь олж дүгнэсэн байдаг.

### *Хоёр. Түүхт хүмүүсийн тухай судалгаа*

Академич Ш.Нацагдорж бол үеийн түүхт хүмүүс, тухайлбал Чингис хаан, Жамухагаас эхлэн Батмөнх Мандухай нар, Чингүнжаваас Тогтохтөр, Манлайбаатар Дамдинсүрэн, Д.Сүхбаатар хүртэл хэдэн зууныг дамжуулан судалгаа хийсэн эрдэмтэн билээ. Академич түүхт хүмүүсийн тухай бичсэн зохиолдоо тэдгээр хүмүүсийн үйл ажиллагааг түүхэн байдалтай нь уялдуулан үнэлэн шүүмжлэх, гаргалгаа дүгнэлт хийх зэрэг онол арга зүйн өв санг залгамж хойч үедээ өвлүүлэн өгсөн билээ. Жишээ нь, 1958 онд бичсэн “Чингис Хасар хоёрын зөрчил” хэмээх томоохон өгүүлэлдээ “Монголын нууц товчоон”, “Лу. Алтан товч”, “Судрын чуулган” зэрэг дотоод гадаадын 10 шахам сурвалж бичгийн мэдээ баримтыг нягдлан судалж Чингис Хасар нарын зөрчлийн үүссэн дотоод гадаад шалтгаан, нөхцөл байдал, учир холбогдол зэрэг талаар маш сонирхолтой дүгнэлтүүдийг хийсэн байдаг. Тухайлбал,

1. Хавт Хасар бол Есүхэй баатар Өэлүн эхийн хоёрдугаар хөвгүүн. Тэмүжиний хүчтэй өрсөлдөгч байсан тул зөрчил үүсэх нь аяндаа зүйн ёсны хэрэг хэмээн үзсэн.

2. Хасарын хав хүч, Бэлгүдэйн бөхөөр 1206 онд Их Монгол улсыг байгуулсан боловч Хасарын гавьяа зүтгэлийг бүрэн гүйцэд үнэлээгүй явдал нь Тэмүжинтэй зөрчилдөхийн бас нэг үндэс шалтгаан болсон хэмээх. Жишээлбэл, Их Монгол улсыг байгуулсны дараа Чингис хаан гавьяат зүтгэлтэн болон өөрийн алтан ургийн үр саддаа өмч иргэн хуваасан байдаг. Зүчи, Цагаадай зэрэг өөрийн хөвгүүдэд есөн мянган

иргэн, найман мянган иргэн хувааж өгсөн боловч харин дүү Хасартаа дөрвөн мянган иргэн өгсөн. Дэмий удалгүй бас хоёр мянга илүү иргэнээ буцааж авсан зэрэг нь Хасарын гомдол тэмцлийг аяндаа үүсгэсэн зэрэг.

3. Хасар Тэмүжиний зөрчлийг шууд харахад ах дүүсийн хоорондох зөрчил шиг байсан ч хэрэг дээрээ энэ тэмцэл нь эцсийн эцэстээ феодалын язгууртны эрх ашгийн төлөөх дотоод тэмцлийн илрэл болох зэргийг дүгнэн гаргажээ. Мөн Тэмүжин Жамуха нарын зөрчлийн тухай өгүүлэхдээ зарим судлаач нар Жамухаг нэг бол ардчилсан үзлийн төлөөлөгч, эсвэл доорд анги бүлгийн ашиг тусыг илэрхийлэгч зэргээр үнэлж бичсэн байдаг. Зарим нь бас түүнийг хоёр нүүртэй, хулжин зүсэр, хутган үймүүлэгч хэмээн тэмдэглэсэн харагддаг.

Академич Ш.Нацагдорж гуай Хасар, Жамухагийн тухай судлахдаа тухайн үеийн нөхцөл байдлыг нягтлан шинжиж Тэмүжин, Жамуха нарын зөрчил бол эцсийн эцэстээ талын язгууртны хэн нь хаан суухын төлөө тэмцэл, өөрөөр хэлбэл “Тэмүжин Жамуха хоёроос хэн нь ч гэсэн юуны урьд өөрсдийн феодалын эрхийн төлөө, феодал ангийн төлөө зүтгэсэн юм” гэсэн сонирхолтой дүн гаргалгаа хийсэн билээ.

#### *Гурав. Сурвалж бичгийн тухай судалгаа*

Сурвалж бичгийн судалгаа бол түүх судлалын зайлшгүй хэрэгцээ шаардлага мөн. Сурвалж бичгийг зөвөөр үнэлэн шүүмжлэх, нээн илрүүлэх, мэдээ баримтыг нь нягтлан харьцуулах, үнэн мөнийг магадлах зэрэг олон талын судалгааны дээр түүхийн судалгаа явагдах бөгөөд түүхийн судлал ч гүнзгийрэн хөгждөг. Академич Ш.Нацагдорж гуай нь “Арван буянт номын цагаан түүх”, “Лу.Алтан товч”, “Алтан эрхи” зэрэг сурвалжийн талаар сонирхолтой өгүүлэл бичиж шинжилгээ хийсэн бөгөөд “Улаан хацарт”, “Дөрвөн аймгийн алба тэгшитгэсэн данс”, “Ардын заргын бичиг”, “Харьяат хошууны дотор дагаж явахаар тогтон тушаасан ухуулах бичгийн эх”, “То ван ба түүний сургаал” зэрэг олон арвин архивын данс материалыг бусдын хамт буюу бие даан оршил сэлт бичиж зүүлт тайлбар хийж олны хүртээл болгосон юм. Энэ бол Монголын түүхийн судалгаанд оруулсан дорвитой хувь нэмрийн нэг болж түүхэнд мөнхөрч байна. Академич Ш.Нацагдорж гуайн талаар Америкийн эрдэмтэн О.Латтиморийн дүгнэн хэлснээр, Ш.Нацагдорж бол Монголын түүхчдийн орчин үеийн сургуультай нэг зэрэг өсч гарсан хүн бөгөөд Монголын түүхийн сурвалж бичгийг хэвлэн, нийтлэх ажлыг үүсгэгч, нарийн төвөгтэй асуудалд мянга мянган утсыг нийлүүлэн нэхэх лүгээ адил маш чадварлаг судалгаа хийдэг эрдэмтэн юм.

Б.Пунсалдулам

(Монгол улс, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)

## **Монголын орчин үеийн түүхийн судалгаа ба академич Ш.Нацагдорж**

Академич Ш.Нацагдоржийн бүтээлүүдийн хамрагдах түүхэн цаг хугацаа өргөн байхын зэрэгцээ судалгааны сэдэв агуулга ч гүн гүнзгий, олон талыг хамарсан байна.

Тэрээр ХХ зууны Монголын газрын харилцааны түүх буюу мал, газрыг өмчлөх харилцааны хэлбэр, нийгмийн анги бүлгүүдийн гарал үүсэл, ялгаа, бүтэц, зэрэг дэв, албан тушаал, албан гувчуур түүний төрөл, ангийн тэмцэл, ардын тэмцэл хөдөлгөөний түүх, Халхын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний түүх, XIX-XX зууны эхэн үеийн Монголын нийгэм эдийн засгийн хөгжил түүнд гарсан өөрчлөлт, шалтгаан, Орос, Монголын харилцаа, дэлхийн зах зээлийн хөгжил, түүний үр нөлөө, Оросын болон дэлхийн хувьсгалт үйл явц, түүний нөлөө, Олноо Өргөгдсөн Монгол улсын татварын бодлого, 1921 оны ардын хувьсгал, түүний феодалыг эсэргүүцсэн шинж чанар, үе шат, шийдвэрлэсэн асуудлууд, БНМАУ-ын нийгэм, ангийн бүтэц, ажилчин ангийн үүсэл хөгжил, Монголын эмэгтэйчүүдийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, Халх голын дайн, Монгол-Зөвлөлтийн найрамдал, гэрээ хэлэлцээрийн түүх зэрэг олон чухал асуудлаар судалгааны үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Сато Норуюки  
(БНХАУ, Фудан их сургууль)

## **Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны Хууль Зүйлийн Бичгийн доторх нэг тогтоолын тухай**

Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны Хууль Зүйлийн Бичиг бол Манжийн үеийн Монголын түүх судлалын үндсэн баримт бичгүүдийн нэг юм бөгөөд тус материалын тухайн судалгаа нэгэнт цөөнгүй байна. Харин түүнд агуулагдаж буй тотоолуудыг тогтоосон учир шалтгаан, үйл явцын талаар судалсан нь олон биш.

Тус илтгэлд ГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичгийн 34-р ботид буй “Хүрээний зэргийн газарт тариа тарих иргэн, худалдаа хийх иргэнийг ялган салгаж үлдэх агуулах нь” хэмээх нэг тогтоолыг жишээ болгоно.

Төр гэрэлтийн 3-р (1823) онд Халх Монголын хойд нутгийн тариалангийн газруудад манжийн түшмэд тариа тарих иргэчүүдийн гэр байшинг шатаасан нэг хэрэг гарсан. Үүнд түүний учир шалтгаан, асуудлыг шийтгэхийн үйл явцыг нягтлан үзэхээр, тус тогтоол тогтоогдсон түүхийн ач холбогдол, мөн тухай үеийн нийгмийн байдлыг тодруулно.

Төр Гэрэлтийн 4-р (1824) онд Улиастайн жанжин Голфунгагийн айлтгалд үндэслэн хоёр шинэ дүрэм тогтоогдсон. Нэг нь Халх Монголд сууж буй иргэдийг яаж захиран хамаарах тухай, нөгөө нь монголчуудын иргэчүүдэд дутсан өр ширийг яаж хөөн төлүүлэх тухай дүрэм юм. Үүний дотор эхнийх нь дээр өгүүлсэн ГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичгийн доторх тогтоолтой бараг ижилхэн агуулгатай. Мөн ГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичигт зөвхөн энэ дүрэм л оруулагдсан.

Харин монголчуудын иргэдэд дутсан өр ширийн асуудал бол Манжийн үеийн сүүл болтол үргэлжилсээр байжээ. Тийм учраас монгол болон иргэний хооронд гарсан асуудлыг байцаан шийтгэхдээ Хүрээний сайд, ГМТЗЯЯ-ны түшмэл буюу заргач нар түүнээс хойш ч ГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичигт “байхгүй” хэрэгт ч мөн анхаарах хэрэгтэй байсан юм.

На. Сүхбаатар  
(Монгол улс, МУБИС)

## **Зүүнгарын хаадын хаан ширээ залгамжлалын түүхийн асуудалд**

Ойрадын чуулганы зүүнгарын хунтайж Галдан 1671 онд зүүнгарын хунтайж Сэнгийн ширээг залгамжлав. Галдан зүүнгарын дотор гарсан зөрчил тэмцлийг шийдвэрлэж улмаар зүүн, баруун гарын ноёдын дэмжлэгийг хүлээн хүчирхэгжээд баруун гарын ахлаач Очирт сэцэн хантай эвдрэлцэж, цэргийн хүчээр буулган авч олон зуун жилийн уламжлалтай Дөрвөн ойрадын чуулганы бүтцийг эвдэн хаант засаглал бүхий улсыг 1676 онд байгуулсан билээ. Үүнийг түүхэнд Зүүнгар улс хэмээн нэрлэдэг. Зүүнгар улс оршин тогтносон хугацаандаа Төв болон Дундад Азид улс төр, эдийн засгийн гол тоглогч байсан төдийгүй аж ахуй, соёлын өндөр хөгжилтэй улс байсан юм.

Зүүнгар улсын хаан ширээнд Галданбошгот (1676-1697), Цэвээнравдан (1697-1727), Галданцэрэн (1727-1745), Цэвээндоржнамжил (1745-1749), Лхамдаржаа (1749-1752), Даваач (1752-1755) нар удаа дараалан сууж байв. Тус илтгэлд Зүүнгарын засаглалын хууль ёсны эрх, эрх өвлөгчид ба төрийн эрх булаалт, түүнд нөлөөлсөн гадаад дотоод хүчин зүйлийн талаар авч үзлээ.

Зүүнгарын хаан ширээнд суух эрх Эрдэнэбаатар хунтайжийн хүү Сэнгэ, Бум нарын хойчист хадгалагдаж иржээ. Зүүнгарын хаан ширээ 5 удаа шилжихдээ хуйвалдаан, хүч хэрэглэсэн нөхцөлд явагдаж өнгөрчээ. Үүнээс үүдэж Зүүнгарт улс төрийн ужиг хямрал үүсч, эцэстээ Манжид эзлэгдэх нэг нөхцөл болсон байна. Зүүнгарын хаан ширээнд суусан дээрх ноёдын уг гарал, эхийн тал, төрсөн цаг үе болон нас барсан шалтгаан, хаан ширээнд суухын төлөөх тэмцэл зэрэг асуудлыг шинээр илэрч судалгааны эргэлтэд орж буй сурвалжид түшиглэн тодруулахыг зорилоо.

С-Х.Д.Сыртыпова  
(ОХУ, Оросын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэн)

### **Монгольские шахматы XIII в.: к вопросу датировки и онтологии шахматной традиции в Монголии**

Миниатюрные скульптуры, отлитые из латуни (состав сплава см. в табл. 1), являются фигурами монгольских шахмат (*шатар*). Представляют собой характерную художественную пластику монгольского стиля, исторические корни которого кроются в искусстве ранних кочевников Евразии, т. н. скифо-сибирском зверином стиле. О том, что «народная монгольская скульптура имеет разительный стилиевой параллелизм с образцами скифо-сибирского анимализма», справедливо писал известный, российский ученый В. А. Кореняко.

Судя по характерному шву, проходящему посредине фигурок животных, литьё производилось традиционным, древним способом с разъёмной земляной формы из двух частей, в которых оттискивалась готовая матрица. Постамент в виде лотосового буддийского трона отлит отдельно, поэтому при соединении фигурок с постаментом копытца несколько деформировались. Разный химический состав сплава говорит о кустарном способе изготовления с отдельным замесом и литьем фигурок. Все пять фигурок посажены на лотосовые постаменты, на таких обычно изображаются божества и культовые предметы. О буддийском характере скульптурок свидетельствует не только использование лотосов, но и полное отсутствие агрессии в обликах воина и животных.

Наиболее информативной для датировки предметов является скульптурка *ноёна* – шахматного короля. *Ноён* представлен как воин в средневековых доспехах, которые носили представители монгольской знати в период завоевательных походов Чингис-хана и его наследников в XIII–XIV вв. На этот же период указывает изображение средневекового монгольского знамени на оборотной стороне спинки трона. Навершием знамени является трезубец – родовая тамга Тулуя, наследника родовых земель Чингис-хана, то есть древней территории собственно Монголии. Знак трезубца использовали в своих печатях потомки Чингисова *отхона*, великие правители монгольских и ближневосточных территорий Мункэ-хан и Хулагу-хан.



Немолодое лицо полководца испещрено морщинами, пушистые усы прикрывают крупный рот. Несмотря на статичную позу со скрещёнными ногами и руками, фигура полна скрытой силы, достаточной гибкости и динамики. Пропорциональное сложение, поджарый живот, решительный жест рук (правая кисть обхватывает левую руку у запястья), резко очерченные пластины доспехов, жёсткие наручи, высокие бортики монгольских сапог, чёткая симметрия композиции создают ощущение крепости и стабильности его обороны.

Монгольский воин изображён без оружия, что соответствует неучастию Угэдэя в военных действиях монгольской армии в период своего правления. Боевой шлем с пышным плюмажем и круглым значком на лобной части выглядит как царская корона или головной убор высокородного господина. Спинка лотосового трона сделана в форме киота, поэтому герой выглядит как буддийский мудрец, погружённый в глубокое размышление о вечных истинах и судьбах своего народа. Лепестки лотосовых постаментов обращены вниз, они имеют широкую и плоскую форму, характерную для непальской изобразительности XII–XIV вв. Это свидетельствует о постепенном усилении непало-тибетских традиций, приходящих на смену уйгурской изобразительности.

В изображениях животных монгольские мастера, очевидно, сохраняли некий автохтонный образец на протяжении столетий. Так, мы видим идентичные облики монгольских лошадок с крупными горбоносими головами, мохнатыми гривами и хвостами, с характерным поворотом голов, а также ревущих верблюдов, чуть приседающих на задние ноги и машущих хвостами; такой же характерный наклон головы *ноёна* в шахматных фигурках XX столетия. Замкнутые линии, чистые контуры, лаконичность, при этом удивительная выразительность художественных средств, динамизм, огромная любовь к животным, характерная для скотоводов, т. н. пухлость или округлость форм – все эти черты монгольской изобразительности воплощены в миниатюрных фигурках шахмат.

Скульптурные изображения несут ярко выраженный национальный монгольский облик, нет никакого сомнения, что моделирование изображений было осуществлено мастером монгольского этнического происхождения. Сюжетная тематика шахматных сражений и их художественное оформление, как правило, отражали историческое время их создания, а идеи, натура черпались художниками из повседневного окружения, вполне конкретных исторических реалий.

Поэтому облики шахматных фигур в истории мировых шахмат, как правило, соответствуют своей эпохе. Всё это говорит в пользу того, что описанные скульптуры были изготовлены, вероятнее всего, около 1247–1257 гг. Во всяком случае, не позднее XIV в., пока ещё была актуальна символика завоевательных походов и не утеряна эстетика средневекового воина. В то же время правящая монгольская элита уже восприняла буддийское учение, в атмосфере уже витало новое осмысление происходящих событий, а изобразительные средства непало-тибетского буддизма стали проникать в народное искусство и ремёсла.

Обнаружение монгольских шахмат, отлитых из латуни, судя по всему, в середине XIII в. свидетельствует о более ранних датах распространения шахмат среди монголов. Многие авторы полагают, что шахматы были восприняты монголами после завоевательных походов на Ближний Восток. О древности шахматной традиции в Монголии говорят и археологические данные. На территории Баян-Хонгорского аймака Монголии есть долина под названием Тоглолтын тала – букв. Долина игр, в которой обнаружены каменные изваяния львов и баранов, форма которых напоминает монгольские шахматные фигурки, а находящиеся рядом прямоугольные каменные ограды называются шатар чулуун – шахматные камни. Памятники датированы VII-VIII вв.

М.М.Содномпилова  
(ОХУ, Оросын ШУА-ийн Сибирийн салбарын  
Монгол, төвд, буддын судлалын хүрээлэн)

## **Сакральные элементы правосудия монгольских народов в правовых системах Российской и Цинской империй**

В правовой культуре монгольских народов была широко распространена практика использования присяги и испытания как правового регулятора, официально признаваемого и в Российской и в Цинской империи. Это действия, в которых власти полагались на справедливое участие или решение сверхъестественных сил.

И присяга и испытание являются нормами, сформировавшимися под воздействием религиозных воззрений и представляют синтез правил и религиозных убеждений, унаследованных от монгольской правовой системы.

Д.Тод

*(Монгол улс, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)*

### **Академич Ш.Нацагдоржийн бичиг, захидлын өв**

Монголын шинэ үеийн түүхийн шинжлэх ухааныг үндэслэгч академич Ш.Нацагдорж монголын түүх судлалыг арвин баялаг эх сурвалж, уламжлалд тулгуурлан судалгааны шинэ арга зүйг нэвтрүүлэн хөгжүүлэхдээ гадаадын монголын түүх судлалтай нягт уялдуулан холбож амжилттай зохион байгуулж ирсэн билээ. Түүний бичиг баримт, захидлуудаас үзэхэд академич Ш.Нацагдорж 60 гаруй жил монголын түүхийн шинжлэх ухаанд зүтгэхдээ дэлхийн түвшинд хүрсэн орчин үеийн түүхийн шинжлэх ухааныг эх орныхоо хөрсөнд тарьж соёолуулан тордон ургуулах ажлын төвд цаг ямагт байж, дэлхийн олон улсын түүхч, монгол судлаачдыг монгол оронтой холбосон гүүр болж, тэд нарыг ном бүтээл туурвихад нь бүхий л боломжоороо тусалдаг байжээ. Тэрбээр зөвхөн эрдэм судлалын ажлаар ч биш, хувь хүнийхээ хувьд олон хүний сэтгэлийг татаж, хайр хүндлэлийг хүлээсэн дотны нөхөр нь байсныг харахад түвэггүй байна.

Боржигин М.Улаанбагана  
(БНХАУ, Нийгмийн Шинжлэх ухааны Академи)

## Шагдар хамба ламд холбогдох түүхэн баримтууд

Шагдар хамба лам гэгч 18 дугаар зууны дунд үеэр Монголын шашны хэрэгт зүтгэж явсан тэр цагтаа бол нэг үе их алдар хүндтэй байсан Халхын лам юм. Тэрбээр Халхын Шидишри бэйлийн хошуунд төрсөн бөгөөд багаасаа сүмд сууж лам болоод залуу насандаа Төвдөд Далай ламын дэргэд ном сурж, хожим нь Халхдаа буцаж ирээд хоёрдугаар дүрийн Жавзандамба Хутагтын дэргэд Дэд хамба цол хүртсэн билээ. Удалгүй Хүрээний ихэс лам нар болон Халхын зарим ноёдын дарамтаар Хүрээнд цөлөгдөж Амарбаясгалант хийдэд суусан байна.

Шагдар хамба гэрийн гарлын хувьд Хүрээний их хамба болон Халхын Зүүн Гарын Цэргийг Захирах Туслах Жанжин Хошой Чин Ван Санзайдоржтой төрөл ураг болдог байжээ. Тодруулж хэлэхэд, Хүрээний их хамба Жамбалборж бол Шагдарын төрсөн ах нь байсан ба Санзайдорж бол Шагдарын зээ хүргэн нь байжээ.

1757 оны эхэнд хоёрдугаар дүрийн Жавзандамба Хутагт таалал төгссөний сүүлээр Санзайдорж чин ван Шагдарыг Амарбаясгалантаас Хүрээнд эргүүлэн авч ирээд Хүрээний шашны үйл хэрэгт оролцуулжээ. 1759 оны зун Санзайдорж Дайчин улсын захын хэрэг захирсан сайдын хувиар Оросын захын хэрэг захирсан сайд Якубтай уулзан Орос, Монголын захын хэргийг шийтгэхээр Хиагтад очиход Шагдар хамбыг дагуулан аваачсан байжээ. Тэр удаа Шагдар хамба Хиагтад нууцаар Буриадын Онон Дацангийн хамба лам Дамбадаржаатай уулзаж Ононы Буриадын хил давж Богд хаанд дагаар ирэхийг хэлэлцсэн байжээ. Шагдар, Дамбадаржаа хоёр уг нь Далай ламын дэргэд хамт шавилж байсан түүхтэй. Мөн тэр жилийн намар Шагдар хамба Халх дөрвөн аймаг болон Хүрээний шавь нарын өмнөөс хоёрдугаар дүрийн Жавзандамба Хутагтын буянд зориулан Лхасад элчлэн явжээ. Шагдар хамба Хутагтын буяны ерөөлийг амжилттай гүйцэтгэж мөн Санзайдоржийн найдлагаар нэг арслангийн арьс олоод 1761 оны хавар Хүрээнд буцан иржээ.

Шагдар Хүрээнд буцаж ирэнгүүт Хүрээний их хамба, эрдэнэ шанзодба нар Санзайдоржоор Тэнгэрийн Тэтгэсэн (ТТ) хаанд айлтгуулж Шагдарыг хишигт мөргүүлэхээр Бээжинд явуулахыг гуйсанд ТТ

хаан зөвшөөрчээ. Шагдар тэр хавар Бээжин орж ТТ хаанд золгосонд хаан түүнд Дархан Бандида Хамба хэмээх цол соёрхсон байна. Яг тэр үеэр Халхын хаад ноёд болон Манжийн хааны хооронд Жавзандамба Хутагтын хувилгааныг тодруулах учраар хэлэлцэж байсан байв. Халхын ноёд лам нар Халхын газраас хувилгаан эрж байхад ТТ хаан харин Төвдөөс тодруулахаар шийдчихээд байв. ТТ хаан Халхын ноёдын айлтгалын хариу Жанжаа Хутагтын үгээр иш учирлан Төвдөөс хувилгаан хайхыг анхааруулсан бөгөөд Жанжаа Хутагтаар Лхасын Диму Хутагтад захиа бичүүлж Төвдийн хүүхдийг хувилгаанаар тодруулахыг шаардсан байна.

Халхын ноёд лам нар ТТ хааны саналыг илээр зөрчиж чадсангүй боловч Халхаас Төвдөд элч явуулж тэндээс олсон хүүхдийг үзэж, хувилгаан мөн эсэх талаар Ламу Чойзонгоос сунтаг эрэхийг гуйсанд, ТТ хаан, олон хүн явуулах хэрэггүй, Шагдар хамбыг цөөн хүний хамт явуултугай гэжээ. Тэр зарлигаар Шагдар хамба Хүрээнээс Бээжинг дайран дахин Лхасыг зорьжээ. Шагдар хамба Лхаст хүрээд Диму Хутагтад золгож Төвдөөс олсон хоёр хүүхдийг үзээд эргэлзээ төрсөн болохоор Диму Хутагтын эсрэг маргаж, Жанжаа Хутагттай хэлэлцэж байж болно гэсэн боловч сүүлд нь Ламу Чойзон Литанаас олсон хүүхэд хувилгаан мөн гэсэн тул аргагүй хүлээн зөвшөөрчээ. Шагдар хамба хэдийгээр Төвдөөс олсон хүүхдийг хүлээн зөвшөөрөх дургүй байсан боловч тэр үйд Жанжаа Хутагт, Диму Хутагт, Ламу Чойзон нар цөм ТТ хаанаас нууц зарлигтай байсан тул Шагдар хамбын эргэлзээ хэрэгт хүрэх боломж байсангүй. Литанаас олсон хүүхдийг Жавзандамба Хутагтын хувилгаан гэж тодлоод, тэр чимээг Диму Хутагт Төвдөд суугаа сайдаар дамжуулан ТТ хаанд айлтгасанд, ТТ хаан Халхын ноёд лам нарт ухуулан зарлажээ. Шагдар хамба Төвдөөс буцахдаа мөн Хятад газраар явж 1762 оны 5 сард Бээжинд хүрж ирээд ТТ хаанд золгоод дахин Халхдаа буцсан байна.

Литанаас Жавзандамба Хутагтын хувилгааныг тодруулсан зарлигийг хүлээн авсаны дараа Халхын ноёд лам нар чуулган нийлж хувилгааныг залж ирэх талаар хэлэлцэж, 1762 оны 10 сард Шагдар хамба Халхын зүүн хоёр аймгийн элч 400 хүнийг авч Хүрээнээс хөдөлж, засагт хан Балдар баруун хоёр аймгийн 400 хүнийг авч, бүгд 800 элч Литанаас хувилгааныг залахаар явсан байна. ТТ хаан мэйрэний занги Лю Баужу гэгч хүнийг гаргаж хамт явуулжээ. Халхын элчид Литанд хүрээд хувилгааныг залж 1762 оны хавар Литанаас хөдөлж олон хоног

явж тус жилийн 8 сард Долоон нуур хүрэв. Долоон нуурт ТТ хааны зарлигаар хувилгааныг Жанжаа Хутагтаас сахил авхуулаад тэндээс Хүрээ рүү аялан 11 сард Хүрээнд ирээд 28-д ширээнд суулгажээ. Энэ бүх үйл явцад Шагдар хамба хувилгааны ойр шадар явж хүүхэд насны хувилгааныг асарч харгалзаж байжээ. Аль эрт Халхын элчид Литан рүү явахын өмнө хойгуур Санзайдорж ТТ хаанд айлтгаж Хүрээний Хамба лам Жамбалдоржийг шинэ хувилгааны номын багшаар томилсон байжээ. 1762 оны 11 сард хувилгаан ширээнд суусны дараа, Санзайдорж дахин хаанд айлтгаж Шагдарыг бас хувилгааны номын багшаар томилсон байна.

1765 онд Санзайдорж, Шагдар хамба нарын Хиагтын амаар Оростой худалдаа хийсэн хэрэг нь илрээд Санзайдорж, Солин, Хүрээний хамба лам Жамбалдорж, дэд хамба Шагдар, эрдэнэ шанзодба Сүндэвдорж нар цөм зэрэг цолоо хасуулсан байна. Удалгүй Халхын зарим ноёд лам нар бас Шагдар хамбыг дээрэнгүй зантай хэмээн Хүрээний сайд Хутурингад заалдсанд, Хутуринга ТТ хаанд айлтаж Шагдарыг Өвөр Монголын Ширээт Хүрээнд цөлсөн байна.

1771 онд Санзайдорж дахин Хүрээ сайдаар томилогдсоныхоо дараа, ТТ хаанд айлтаж Шагдарыг Ширээт Хүрээнээс Халхад буцаан ирүүлэхийг гуйсанд ТТ хаан зөвшөөрсөнгүй. 1777 онд, Жанжаа Хутагт ТТ хаанд айлтаж Шагдарыг ялнаас нь чөлөөлөхийг гуйсанд ТТ хаан аргагүй зөвшөөрсөн боловч Халхад буцаасангүй, харин Бээжинд авчран Найралт Найрамдуу Сүмд эмчийн сургагчаар ажиллуулсан байна.

Манай энэ өгүүлэлд Шагдар хамбад холбогдох Монгол, Манж хэлний түүхэн баримтуудыг авч үзэн, Өвөр Монголд хадгалагдаж байгаа Шагдар хамба ламын тууж гэх нэгэн сонин сурвалжийг танилцуулах болно.

Уранцэцэг  
(БНХАУ, Өвөр Монголын  
Эдийн засаг аж ахуйн их сургууль)

**Чин, Иргэн улсын үе дэх Өвөр Монголын  
өрх амын данс, жич түүний үнэ өртөг  
(Хөх хотын түмэдийн жишээн дээр)**

Өвөр Монголын өөртөө засах орны төв Хөх хотын түмэд зүүн хошууны түүхийн архивт хадгалагдаж буй Хөх хот түмэдийн Чин, Иргэн улсын үеийн монгол, манж, хятад үсгийн өрх амын дансанд эрийн данс, өрх амын данс, өрх ам нэрийн данс, өрх ам газрын данс мэт олон төрөлжиж, их хэмжээний өрх амын дансны мэдээ агуулагдаж байдаг.

Эдгээр өрх амын данс нь тухайн үеийн түмэд орны хүн амын хөгжил хувирал, аж ахуй, цэргийн явдал болон газар орны хамааралт зэрэг мэдээнүүдийг хангадагаараа тун өртөг өндөр түүхэн материал болж судалгааны үнэ цэнтэй мөртөө Монгол орны өрх амын хамааралтын өвөрмөц онцлогийг тусгасан байдаг.



Хагихара Мамору  
(Япон улс, Кообэ Их сургууль)

## **Хүний бие худалдахыг цаазалсан Манжийн үеийн Монгол цаазын бичиг**

Манжийн эрхшээлд байсан үеийн Монгол цаазын бичиг дотор, хүний бие худалдахыг цаазалсан зүйл нь 3 байсан юм. Тэнгэрийн тэтгэсний үеийн Монгол цаазын бичгийн 2 дугаар ботийн сүүлийн хэсэгт 1 зүйл (*Гадаад монголчуудыг зоригоор дотоод хушууны улсад үл худалдуулах*, 1772 онд тогтоосон), бас 10 дугаар ботид 1 зүйл (*Монгол хүн дотроо аргадаж авч худалдах нь*, 1683 онд тогтоосон) байсан.

Төр гэрэлтийн үеийн Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны Хууль Зүйлийн Бичиг (ГМТЗЯЯХЗБ)- ийн 9 дүгээр ботид бас 1 зүйл (*Зоригоор албат нарыг худалдах хүн ам оргон сарниулахыг нь ялган салгаж яллахуй нь*, 1839 онд тогтоосон) байна. Эдгээр 3 зүйлийн тухай бол Японы Шимада багш нь нарийн судласан боловч Манжийн үеийн монголчуудын нийгмийн байдалтай харьцуулж үзсэн судлал нь байхгүй юм.

1683 оны зүйлд бол *Аливаа монголчууд дотроо аргадаж зүгээр хүнийг боол шивэгчин, эм, бага эм, хөвүүн, ач болгон худалдвал худалдсан ба эс худалдсаныг ялгалгүй зуун ташуурдаж гурван есөөр торго*, гэж тогтоосон юм. Энд хэлж байгаа зүгээр хүн бол боол биш сумны ард эсвэл хамжлагын ард байх ёстой.

1772 оны зүйлд бол *Аливаа дансанд оруулсан монголчуудыг хэрхэвч бээр зоригоор худалдан өгч үл болно. Ер дансанд эс оруулсан жантур хэмээвч бээр бас ч мөнхүү тус хушууны дотор харилцан худалдан авах ба худалдан өгөхөөс гадна*, гэж тогтоосон бөгөөд энэ данс нь 4 жилд нэг удаа ГМТЗЯЯ-нд өргөдөг байсан *Тайж түшмэд сум хамжлагын ардыг зүйл дараалан төөлж өргөх данс* байх ёстой. Тийм учраас сумны ард ба хамжлагын ард нь хоёулаа худалдахыг цаазлагдаж байсан гэж ойлгох хэрэгтэй. Харин энд байгаа жантур гэдэг үг нь хятад үг бөгөөд Манжийн найман хошууны цэргийн газар тариаланд ажилладаг дор зэрэгтэй хятад тариачин байна. Энд бол хамжилгаас дор зэрэгтэй Монгол хүн бөгөөд дансанд оруулсангүй боол хүн байх ёстой.

1839 оны зүйлд бол *Монголчууд зоригоор идэр эр хамжлагын эрийг арванаас дорогш худалдах ба, худалдан авахуйг нь тодорхой байцааж*

*магад болбоос, өөр өөрийн таван есөн мал торго, гэж тогтоосон юм. Энд бол идэр эр (сумны ард) ба хамжлагын эр гэж дурдсан учраас хамжлага бас худалдахыг цаазалж байсан гэж тодорхой ойлгож чаддаг юм.*

Ингэж үзвэл, 1683 оноос хойш Манжийн засгийн газар нь монголын ардын дотор зөвхөн боол хүнийг худалдахыг зөвшөөрч байсан юм. Харин хамжлагын хүнийг худалдсан жишээ бас нэлээд олон байдаг. Манжийн засгийн газар нь хатуу цаазалж байсан биш гэж бид нар ойлгож чадна.

Хасбагана  
(БНХАУ, Нийгмийн шинжлэх ухааны Академи)

### **Чин улсын үеийн Их Зуугийн чуулганы эл өртөөнд холбогдох хэдэн асуудал**

Чингийн үеийн Монгол дахь Цагаан хэрэмний таван хаалганы өртөөнүүдийг Энх Амгалангийн гучин нэгдүгээр ба гучин хоёрдугаар онд байгуулсан юм. Үүнд Шүрхий хаалганы өртөөг захирах хэлтсийн түшмэлийн захирах Их Зуугийн чуулганы зургаан өртөөг тэр үеийн Ордосын зургаан хошуунаас тус тус хуяг ардыг гаргаж, газар бэлчээр хуваан өгч байгуулсан билээ. Тэдгээр өртөөнүүд бол: Донсухай, Зэгстэй, Баянбулаг, Ар Урт, Барсухай, Цагаан задгай зэрэг зургаан өртөө болно.

Тус өгүүлэлд голдуу Чингийн үеийн Их Зуугийн чуулганы Зүүнгар, Хангин, Отог, Жүн ван зэрэг хошуудын засаг яамны данс ба ХХ зууны дөчөөд онд Японы өмнөд Манжийн төмөр замын компанийн талаас тухайн оронд байцаалт хийсэн суурин дээр бичсэн мэдүүлэлтийн материал зэрэг олон зүйлийн сурвалж сэлтэд түшиглэн, тэр зургаан өртөөний газар зүйн байршил, газар нутгийн зааг, өртөөний сүм хийд өртөө улааны зам шугам, ажил алба, хамааралт ба хувиралт, өртөө тавины ардын учир зэргийн агуулгыг түүхийн хувирал хөгжлийн талаас шинжлэхийн дагууд өнгөрсөн судалгаанд зохих хэмжээний шүүн тунгаалтыг хийсэн байна.

Н.Хатанбаатар  
(Монгол улс, ШУА ТАХ)

## **Халхын Еншөөв тайж нарын уг гарвалын тухай**

Монголын түүх судлалд XVIII-XX зууны эхэн үеийн Халхын бүх аймаг, хошуудын эрхийг баригч засаг ноёд болон тайж нар нь Батмөнх даян хааны отгон хөвгүүн Гэрсэнз жалайр хунтайжийн удамчир, залгамчирууд мөн хэмээн үздэг билээ. Гэсэн хэдий боловч Халхын 4 аймгийн 86 хошууны засаг бус тайж нарын нийт бүтэц бүрэлдэхүүнийг нарийвчлан судалж үзэхүл, тэдгээрийн дунд басхүү угсаа удмын зааг ялгаа оршин байсаар ирснийг мэдэж болно.

Монгол улсын халхчуудын угсаатны бүтэц, овгийн бүрэлдэхүүнийг шинжлэн судлах угсаатны зүйн хээрийн шинжилгээ, хэлний зүй, нутгийн аялгууг сурвалжлах эрдэмтдийн судалгаа болон архивын данс хараанаас үзэхэд Монгол улсын халхчуудын дунд еншөөв, еншөөбү, юншээбүү, юншээ хэмээх адил үндэс агуулгатай боловч дуудлага, бичлэгийн талаар ялгаатай овогтон (хойшид еншөөв хэмээн товчилно-Н.Х) цөөнгүй тархсан нь мэдэгдэж байна. Үүнд. өдгөө Монгол улсын Дорнод аймгийн Халхгол, Булган, Матад; Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан; Сэлэнгэ аймгийн Дархан, Ерөө, Алтанбулаг; Булган аймгийн Уньт, Хутаг-Өндөр; Дорноговь аймгийн Эрдэнэ, Дундговь аймгийн Дэлгэрхангай; Говь-Алтай аймгийн Баян-Уул, Дарви, Хөхморьт сумдад эдгээр еншөөв овогтон буюу заримд нь еншөөв тайж нарын бүтэн отог баг буюу хожмын нэршлээр нэгдлийн бригад бүртгэгдсэн байна. Дээр дурдсан еншөөв овгийн тархацаас үзэхэд Манж, Богд хаант Монгол улсын үеийн засаг захиргааны хуваариар бол Дорнод аймгийн Халхгол сум нь Сэцэн хан аймгийн Илдэн вангийн; Баянтүмэн, Булган сум нь мөн аймгийн Чин ачит засгийн хошуу; Матад сум нь мөн аймгийн Үйзэн гүний хатагин хошууны нутаг юм. Мөнхүү Дорноговь аймгийн Эрдэнэ сум нь Түшээт хан аймгийн Мэргэн гүний хошуу, Цогтой гүний хошууны зааг нутаг, Говь-Алтай аймгийн Баян-Уул, Дарви, Хөхморьт сумд нь Засагт хан аймгийн Баатар засгийн хошуу болно.

Түүхэн сурвалжаас үзэхэд, Еншээбүү нь XVI-XVII зууны эхэн хүртэл Монголын баруун 3 түмний бүрэлдэхүүнд байсан нь мэдэгдэх бөгөөд Монголын их хаан Лигдэнгийн засаглалыг эсэргүүцэн тэмцэж

байжээ. Бидний үзэж байгаар бол Еншээбүү аймгийн үр хойчис нь Монгол улсын халхчуудын угсаатны бүрэлдэхүүнд тодорхой хэмжээгээр оролцсон гэж үзэж байна. Энэ тухайд холбогдох нэгэн түүхэн мэдээ нь түүхч Ломи-ийн “Боржигид овгийн түүх”, “Долдугаар хөвгүүн Буяндара ноён Юншээбү аймгийг эзлэв. Үүний үрс халхын газар буй” гэсэн байна. Эндээс үзэхэд, Юншээбүү аймгийг ноёлж байсан Барсболд жононгийн хөвгүүн Бодидара тайжийн угсааны нэлээд тайж нар Өвөр Монголын аймгууд XVII зууны 20-30-аад оны үед Лигдэн хааны дайн хөлд доройтож, удалгүй Манжийн эрхшээлд орох үеэр тэр үед тусгаар байдлаа хадгалж байсан угсаа нэгтэй Халхад түшиж дагасан байх түүхэн үндэстэй юм.

Бид Монгол улсын Үндэсний Номын сан, Үндэсний Төв Архивын гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй тайж нарын гэрийн үеийн бичмэл, уг эх болон ойрхи жилүүдэд нийтлэгдсэн БНХАУ-ын Түүхийн нэгдүгээр архивт хадгалагдаж буй XVII зууны эхэн үеийн архивын данс бичгүүд зэрэг эх сурвалжуудад тулгуурлан Халхын зарим аймаг, хошуудад байсан еншөөв тайж нарын уг гарвалын тухай зарим тодруулга хийхийг зорив.

Бидний судалгаанаас үзэхэд, Барсболд жононгийн угсааны еншөөв тайж нар Манж Чин улсын үед Халхын зүүнгарын Сэцэн хан аймаг, Халхын баруун гарын Засагт хан аймгийн нутагт ч оршин сууж байсан болох нь түүхэн сурвалж бичиг, аман түүхийн мэдээ баримтаас тодорхой болж байна.

Хориүчи Каори  
(Япон, Тохокү их сургууль)

**Чин улсын үеийн Монгол дахь “тэжээх”-ийн асуудалд:  
Монголын засаг захиргааны асуудлаас**

Уг илтгэлд Манжийн үеийн Монгол дахь “тэжээх”-ийн асуудлыг засаг захиргааны асуудлын хүрээнд авч судлав.

Миний үзэж байгаагаар, тухайн үеийн Монголчууд аймаг, хошуудаар хуваагдан оршдог байснаас гадна, хошуун дотроо мөн бүлэг бүлгээр байлгаж нэгэн дор нутаглуулснаар дараахь мэт засаг захиргааны үйл ажиллагааг явуулдаг байв. Үүнд, алба гүйцэтгэх, тогтоол шийдвэрийг дамжуулах, гэмт хэрэг, зөрчил зэргийг гарахаас сэргийлэх ба шийтгэн зохицуулах, тэжээн тэтгэх зэрэг болно. Энэ удаа тэжээн тэтгэх асуудлыг авч үзсэнээр, энэхүү ойлголтыг батлан харуулав.

Манжийн үеийн Монголын архивын сурвалжуудад тэжээн тэтгэхтэй холбогдох хэргүүд багагүй буй. Сэцэн хан аймгийн Чин Ачит вангийн хошууг жишээ болгон задлан шинжилснээр, дараагийн зүйлс тодорхой болов. Үүнд, өвчтөй, настай, үгээгүү хүмүүсийг тэжээн тэтгэхэд хошуу тус бүртээ хариуцдаг байсан бол хошуун дотроо тэжээн тэтгэх асуудлыг сум, отогт нь даалгадаг байв. Мөн энэхүү тэжээх шаардлагатай хүмүүсийг хураан цуглуулж, түүний биеийг нь заавал сум, отгийн дотроо байлгах ёстой байв. Нөгөөтэйгүүр, сарнин яваа хүний ихэнх нь хоосорч ядуурсныг учир шалтгаан болгон өчиг өчдөг байсныг авч үзвэл, ядуурсан хүмүүсийг уг харьяат хошуу, сум, отгийн дотроо тэжээн тэтгэж, амьдрах арга олгож өгснөөр сарнин тараалгүйгээр “бүлэглэн нутаглах” хэлбэрийг хадгалж байсныг мэдэж болох юм.

Дээр дурдсанчлан уг илтгэлд манжийн үеийн Халх Монголын архивын сурвалжийг судалснаар, “тэжээх” асуудал нь тус нийгмийн засаг захиргааны хувьд чухал зүйл байсан бөгөөд түүнийг биелүүлэхэд монголчуудыг бүлэг бүлгээр нутаглуулдаг байсныг харуулав.

Хөхбаатар  
(Япон улс, Шоова эмэгтэйчүүдийн их сургууль)

**Бүгд Найрамдах Буриад Улсын номын санд байгаа  
Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын материал:  
“Dotuyadu Mongyul-un arad-un qubisyaltu nam-un  
ündüsün jorilta”-ын тухай**

Оросын Холбооны Бүгд Найрамдах Буриад Улсын Улаан-Үд хот дахь “Institute for Mongolian Buddhist and Tibetan Studies Center of Oriental Manuscripts and Xylographs”-ын номын санд, 1925 онд байгуулагдсан Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намаас хэвлэн гаргасан “Dotuyadu mongyul-un arad-un sedgöl” (1-8 дэвтэр) байдгаас гадна, тус намаас гаргасан доорхи 7 төрлийн хэвлэл материал (зарим нь хоёр дэвтэр) байдаг билээ.

1. “Dotuyadu mongyul-un arad-un yeke qural-un beledkel-ün qural-ača neyite-dür tungqaylan jarlaqu bičig”.

2. “Dotuyadu mongyul-un arad-un qubisyaltu nam-un töb qoriyan-ača keblen yaryaysan dürim-i dour-a jiyaysan bičibei” (Тодорхой гарчиг байхгүй).

3. “Dotuyadu mongyul-un arad-un qubisyaltu nam-un nigedüger yeke qural-ača olan tümen arad neyite-dür tungqaylan jarlaqu bičig”, Dotuyadu mongyul-un arad-un qubisyaltu nam-un töb qoriyan-ača keblen yaryabai (улаан ба хөх үсэг, зургийн гадартай, 2 дэвтэр, агуулга нь адил).

4. “Dotuyadu mongyul-un arad-un qubisyaltu nam-un töb qoriyan-ača баруу mongyul-un olan tümen arad ba bayatur joriy бүкүи jalaqu ider aq-a degüü nar tan-a tungqaylan jarlaqu” bičig (Тодорхой гарчиг байхгүй).

5. “Dotuyadu mongyul-un arad-un qubisyaltu nam-un töb qoriyan-ača dotuyadu mongyul-un jiryuyan čiyulyan ba ordus баруу alaša еjen-e jergeyin olan mongyul aq-a degüü nar tan-du jarlan sonusyaqu tusaйayilan sengeregülkü” bičig (Тодорхой гарчиг байхгүй).

6. “Dotuyadu mongyul-un jobalang-tu bayidal”, Dotuyadu mongyul-un arad-un qubisyaltu nam-un töb qoriyan-ača keblen yaryabai (улаан ба хөх үсэг, зургийн гадартай, 2 дэвтэр, агуулга нь адил).

7. “Dotuyadu mongyul-un arad-un qubisyaltu nam-un üндүсүн jorilta” (гар бичмэл ноорог).

Эдгээр хэвлэл материалын дотроос, 1. “Dotuγadu mongγul-un arad-un yeke qural-un beledkel-ün qural-ača neyite-dür tungqaylan jarlaqu bičig” ба 7. “Dotuγadu mongγul-un arad-un qubisγaltu nam-un üндүсүн jorilta”-оос бусдыг нь, 1925 оны 12 дугаар сарын 25-ны үеэр, Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын төв хорооны дарга Сэрэндонров (Бай Юнти) болон тус намын төв хорооны нарин бичгийн дарга Мэрсээ (Го Даофү) МАХН-ын төв хороонд илгээн, Монгол улсаас ч хамаа бүхий хэвлэлээ явуулж өгөхийг хүссэн байна (Chaolumeng “Zizhi yu geming: Neimenggu renmin gemingdang lishi yanjiu 1917-1947. Neimenggu Daxue boshi lunwen) (Цолмон “Өөртөө засах ба хувьсгал: Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын түүхийн судлал 1917-1947. Өвөр монголын их сургуулын докторын өгүүлэл) 2017.5. 136-тал). Тийм болохоор, эдгээр хэвлэл материалууд нь, Монгол Улсын Үндэсний Төв Архивын Харьяа Монгол Ардын Намын Баримтын Төв Ц7-1-19:37-д олон тоогоор хадаглагдаж байна (тодорхой тоо баримтыг “Chaolumeng, 2017.5”-ын 136-талаас лавлана уу). Үүнтэй холбогдуулан, дээр дурдсан олонх материал нь Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын түүхийн хамаа бүхий судалгаанд ашиглагдсан байдаг. Харин, 7. “Dotuγadu mongγul-un arad-un qubisγaltu nam-un üндүсүн jorilta” (гар бичмэл ноорог, 36 хуудас)-ын тухай тодорхой судалгаан ба тус материалыг ашигласан судалгаан хараахан гараагүй гэж ойлгож байна. Энэхүү “Dotuγadu mongγul-un arad-un qubisγaltu nam-un üндүсүн jorilta” нь бичигдсэн цагийн хувьд дээр дурдсан бусад хэвлэл материалуудаас их хожуу байлаа гэдгийг түүний агуулгаас ойлгож болно. Тус гар бичмэл нооргийн агуулга нь Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын зорилтын хувьд “Японы империализмийг эсэргүүцэх”-ийг гол болгосноос гадна, тус намын төв хорооны дарга Бай Юнти болон нарийн бичгийн дарга байсан Мэрсээг “хувьсгалын хүчнийг ашиглан худалдаж уравсан” гэх мэтээр, нэг бус удаа нэрийг нь дурдан хатуу шүүмжилсэн байгаа болохоор, тус материал нь, Бай Юнти болон Мэрсээгийн тушаалыг огцруулсан 1927 оны 8-дугаар сарын тус намын “Улаанбаатар дахь онцгой их хурал”-аас хойно байснаар үл баран, 1928 оны намар болсон “Хөлөнбуйрын бослого”-ос болж Мэрсээ тус намын доторх удирдах байр сууриа бүрэн алдсанаас хойно бичигдлээ гэж таамаглаж болох юм.

Харин, бараг бүтнээрээ шахуу байгаа “Dotuγadu mongγul-un arad-un sedgöl” (1-8 дэвтэр) нь зөвхөн Буриад улсад хадаглагдаж байгаа ба дээрх 7 төрлийн хэвлэл материал Буриад улсад байгааг бид тухай



үед тус намын тэргүүлэгчдийн нэг байсан ба тус намын олон хэвлэл материалын бичиж найруулах ажлыг голчлон гүйцэтгэж байсан Монгол улсын хувьсгалын зохиолч С.Буяннэмэх 1926 онд Дээд-Үд хотод очиж ажиллахдаа авч очлоо гэж үзвэл, “Dotuyadu mongyul-un arad-un qubisyalту nam-un üндүсүн jorilta” нь харин С.Буяннэмэх Буриад Монголоос Монгол улсдаа буцаж ирсэн 1927 оноос хойно бичидсэн болох юм. Тиймээс энэхүү материал нь яагаад Буриадад хадаглагдаж байгааг нийт Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын хэвлэл материалууд нь яагаад Буриад улсад харьцангуй олон хадаглагдаж байгаа вэ гэдэг асуудалтай холбогдуулан дахин бодож үзүүштэй байна. Тус илтгэлд “Dotuyadu mongyul-un arad-un qubisyalту nam-un üндүсүн jorilta” хэмээх Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намтай хамаа бүхий гар бичмэлийг, ерөнхий байдал ба агуулгыг нь тус намын түүхэн байдалтай холбогдуулан хэлэлцүүлэх болно.

Боржигин Хөхмөчир  
(БНХАУ, Өвөр Монголын их сургууль)

## **Property and Inheritance of Mongol Nobleman Tabunang in Kharchin Region during the Qing**

The previous studies of property and inheritance in Mongolian society are focusing on the two points, as below. Firstly, based on the legal history to investigate the content, feature and origin of the laws which were recorded in various codes. Japanese scholar Shimada Masao is the outstanding one in this research field. In his book *Studies on the Mongol codes of Qing*, he compared *Mêng-ku lü-li* (《蒙古律例》) with *Li Fan-yuan Tse-li* (《理藩院则例》) item by item, and examined fact that during the different periods, Qing had different regulations of legislation to Mongol. He also pointed out that as consolidating rule under the Qing in Mongol, Chinese mainland's legal system was beginning to permeate into the Mongolian society and original Northern Eurasian legal system faded away. Secondly, based on the social history to discuss the property inheritance of customs in Mongol such as the youngest son's inheritance, concentrating allocation. Aoki Tomitaro has studied on this aspect.

However, either laws relating to property inheritance in Mongol or early studies of social history, there is few systematic study which investigate the “property” itself. Thus, most of the studies focused on the problem of “inheritance”. Shortage of the archives is the key problem of that. In recent years, more and more archives are opened to the public. Consequently, it is useful to study the range and nature of property itself.

Therefore, in this paper, I elaborate on the problem of “Property” and “Inheritance” of the Mongol noblemen, based on the personal collections and historical records which are relating to the Mongolian noblemen Tabunang's property in the Kharchin region during the Qing.

Хурц

(БНХАУ, Өвөр Монголын Багшийн их сургууль)

## **Монголын боржигин овогт язгууртад харилцан ураг элгэн бололцсон учраас сэдэвлэх нь**

Эртний монголчуудын ураг элгэн бололцох ёсонд эцэг нэгтэй нэг овгийн дотроо ураглахыг чанга цээрлэдэг. Дундад зууны Монголын түүхэнд хиад ястай боржигин овогт Монголын их хааны алтан урагтан болох цагаан ястан тайж нарын дотор, Чингис хаан хийгээд түүний дүү нарын хойчис нь хоорондоо “ураг тайж” хэмээгдэх болж, Чингис хаан буюу Хасар, Бэлгүтэй, Хачиун, Отчигиноос тус тус салбарласан тайж нар нь хоорондоо “төрөл тайж” хэмээн дуудагдах болжээ.

Харин XVI зууны дундач үеэс эхлэн Монголын хаадын угсаа нь Хасар, Бэлгүтэйн хойчис болох боржигид язгууртантай харилцан ураг элгэн болох үзэгдэл буй болжээ. Жишээлбэл, Хавт Хасарын арван тавдугаар үеийн хойчис Нонон үйзэнгийн охин Байхан зул нь Алтан хааны омбол Сүмэр хунтайжтай ураглаж, дөтгөөр дүрийн Далай лам Ёндонжамцыг төрсөн. Адил үеийн Бэлгүтэйн хойчис Ном тэмээт нь Алтан хааны охин Аюуш авайтай урагласан, мөн үеийн Хасарын арван дөрөвдүгээр үеийн хойчис болох Ар хорчины ноёдын дээдэс Багун ноён нь Бодь алаг хааны охинтой ураглаж, Багун тавнан хэмээгдэж байсан нь даруй үүний тухай анхны жишээс.

Монголын боржигид овогт хаадын угсаа Чингис хааны дүү нарын хойчистой харилцан ураг элгэн бололцсон нь Барсболд жононгоосоо Сайн алаг хаан (1517-1519) болсон ба түүний гурван хүү Гүнбилэг мэргэн жонон, Алтан хаан, Баясгал хүндлэн хаан баруун гарын гурван түмнийг ноёлсон, мөн тэд гурвуул Бодь алаг хааныг эзэмдэн Урианхан түмнийг хуваалцсан, Хасарын хойчисоос ноёлсон Хорчин түмнийг бутаргасан, Бэлгүтэйн хойчисоос эрхшээсэн Их түмнийг залгисан түүхтэй шууд харьцаатай байдаг. Түүний үр дүнд Гэрсэнзийн долоон хөвүүд хамгийн их ашиг хүртэж Ар Халх түмэн болж бүрэлдсэн, Дарайсун гүдэн хаан, Хургач Хасар, Хүймөнх Тасхараар түрүүлсэн монголын зүүн гарын язгууртад Хэрлэн, Халх гол, Онон мөрний сав газраас Шармөрөн, Нуун мөрөнд нүүдэллэж ар өлгийн цахар, өвөр таван отог халх, Нуун хорчин зэрэг Дорно монголын улс буюу отгууд болж тархан бүрэлдсэн, цаашлан XVI зууны сүүлчээс XVII зууны эхний үеийн Монголын хааны эрх шашны эрхэд орлогдсон бага хаадын ертөнц буй болсон зэрэг аль олон асуудал цувж гарсан юм.

С.Цолмон

(Монгол улс, ШУА Түүх, археологийн хүрээлэн)

## **Хубилай хааны түүхэн үүргийг үнэлэх талаарх академич Ш.Нацагдоржийн үзэл баримтлалын тухайд**

Өнгөрсөн зууны түүх бичлэгт олон түмний тэр дундаа ард ангийн гүйцэтгэсэн үүргийг өндрөөр үнэлж түүхэн бодит хүний өөрөөр хэлбэл удирдагчийн үүргийг орхигдуулдаг байсан нь нийтлэг үзэгдэл байв. Тэр ч ёсоор монгол болон дэлхийн түүхэн хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсэн их хаадын тухайлбал Чингис хаан, түүний ач хүү Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүргийг социализмын үеийн монголын түүх бичлэгт зохих ёсоор судлаагүй, судлах нь ч хязгаарлагдмал байсан юм. Харин монгол төрийн зүтгэлтэн, түүхч А.Амар 1934 онд бичсэн “Монголын товч түүх” хэмээх зохиолдоо Хубилай хааны гүйцэтгэсэн үүрэг, түүний түүхэнд эзлэх байр суурийг анх удаа үнэн зөвөөр үнэлэх санааг товч боловч гаргасан байдаг юм. Гэвч тухайн үед зарим түүхчид А.Амар түүхчийн санааг үл зөвшөөн Хубилай хааны түүхэн үүргийн талаар өгүүлэхдээ Монголын улс төрийн төвийг Хятад руу шилжүүлэн монголын түүхэнд сөрөг үүрэг гүйцэтгэсэн, хятадын соёлыг дээдлэгч, урвагч гэх зэргээр үнэлж өгүүлсэн нь дийлэнх хувийг эзлэж байв.

Академич Ш.Нацагдорж “Монголын феодализмын үндсэн замнал” зэрэг нэгэн сэдэвт зохиолдоо Хубилай хааны түүхэн үүргийн талаар өөрийн үзэл бодлоо тухайн үед зөвшөөрөгдөх хэмжээнд товч илэрхийлж байснаа 1998 онд хэвлүүлсэн “Хубилай сэцэн” хэмээх нэгэн сэдэвт бэсрэг зохиолдоо тодорхой дэлгэрүүлэн өгүүлсэн байдаг.

Уг бүтээлд академич Ш.Нацагдорж Хубилай хааны тухайн үеийн судалгаа, үнэлэмжийн талаар өөрийн санал бодлыг илэрхийлсэн байдаг. Үүнээс дурдвал зарим судлаач Хубилайг Их Монгол улсын хаан суух уламжлалт ёс төрийг зөрчин, хаан ширээг булааж, Монголын төрийн төвийг харь оронд шилжүүлсэн, Монголыг хятадчилсан, тэр ч байтугай монгол угсаатан бутран сарниж, эцэстээ Манжийн эрхшээлд орсон нь Хубилайн балаг хэмээн батлахыг оролдож байна. Чухамдаа Хубилайг ийнхүү яллах нь зөвхөн манай Монголын түүх бичлэгт байгаа бөгөөд өөр ямар ч улсын түүхчид Хубилайг улс үндэстнээс урвасан этгээд хэмээн бичээгүйг бид мэдэх билээ гэж харамсан бичсэн байдаг.

Тиймээс энэхүү илтгэлд академич Ш.Нацагдорж 1998 онд Хубилай сэцэн хэмээх нэгэн сэдэвт бэсрэг зохиол бичиж Хубилай хааны түүхэн үүргийг тухайн үеийн түүхэн үйл явдлын дэвсгэр дээр бодитой үнэлэх үнэлэмж, санаа оноо дэвшүүлсэн тэр нь хэр бодтой байсан тухайд дэлгэрүүлэн өгүүлэх юм.

Д.Цэвээндорж  
(Монгол улс, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)

## **Монгол, Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедици (МЗТСХЭ)**

Монгол-Зөвлөлтийн эрдэмтэд хамтран Монгол улсад судалгаа хийх ажлыг 1948-1949 онд (С.В.Киселев, Х.Пэрлээ) Монгол гүрний нийслэл Хар хорин хотын малтлагаар эхэлсэн. Гэвч нэг хэсэгтээ тасалдаж байгаад 1960-аад оноос Зөвлөлтийн нэрт эрдэмтэн А.П.Окладников Монголын чулуун зэвсэг судлах ажилд ихээхэн анхаарал тавьж өөрийн шавь Д.Дорж (Монгол талын төлөөлөл, удирдагч)-ийн хамт идэвхитэй судалгаа явуулж эхэлсэн юм. МЗТСХЭ (Монгол-Зөвлөлтийн Түүх соёлын хамтарсан экспедици) 1967 онд анх байгуулагдсан боловч 1969 оноос албан ёсоор нэрлэгдэх болсон юм. Экспедицийн удирдагчаар ЗСБНХУ-ын талаас академич А.П.Окладников, Монгол талаас академич Ш.Нацагдорж (хожим Д.Дорж) нар ажиллаж байсан юм. Тус экспедици нь Чулуун зэвсгийн (палеолитын), Хүрэл ба төмөр зэвсгийн судалгааны анги, Хот судлалын анги, Бичээс судлалын анги, Угсаатны зүй судлалын анги хэмээх таван ангитай ажиллаж байсан билээ. МЗТСХЭ-нь үндсэндээ 1990 он хүртэл ажиллаж ирсэн бөгөөд 1990 оноос зарим ангиудын ажиллагааг зогсоон, Чулуун зэвсгийн судалгааны анги, Хадны зураг судалгааны анги Монгол улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Археологи-Угсаатны хүрээлэн үргэлжлүүлэн ажиллуулах болсон юм.

Чулуун зэвсгийн судалгааны ангид А.П.Окладников, Д.Дорж, А.П.Деревянко, Д.Цэвээндорж, И.В.Асеев нарын эрдэмтэд оролцож ажлаж байсан бөгөөд тус шинжилгээний анги Монгол улсын ихэнх хэсгийг хамарсан хайгуул, судалгаа явуулж Тамсагбулаг, Хэрлэн мөрний хөвөөний дагуух неолитын оршуулгыг илрүүлэн судлаж, Ховд аймгийн Манхан сумын Хойд Цэнхэрийн агуйн зургыг судлан судалгааны үр дүнгээр А.П.Окладников “Центрально-Азиатский очаг первобытного искусства” (Новосибирск. 1972), Д.Дорж “Неолит Восточной Монголии” (УБ. 1971), Д.Дорж, Д.Цэвээндорж “Монголын палеолит” (УБ. 1978), В.Е.Ларичев “Палеолит Северной, Центральной и Восточной Азии” (Новосибирск. 1972), А.П.Окладников “Петроглифы Центральной Азии” (Ленинград. 1980), А.П.Окладников “Петроглифы Монголии” (Ленинград. 1981), Д.Цэвээндорж “Монголын хүй нэгдлийн урлагийн дурсгал” (УБ. 1983), “Палеолит и неолит Монгольского Алтая” (Новосибирск. 1990)

зэрэг нэгэн сэдэвт болон хамтын бүтээлүүдийг туурвижээ.

Хүрэл, төмөр зэвсгийн түрүү үеийн нүүдэлчдийн дурсгал судлах анги Д.Наваан, В.В.Волков, Д.Цэвээндорж нарын удирдлагаар ажиллаж Хүрэл зэвсгийн үеийн буган чулуун хөшөө, дөрвөлжин булш, хиргисүүрийг бүртгэн судлах, хайгуулын зэрэгцээ цөөн тооны булш малтан шинжилсэн юм. 1957 онд Д.Доржсүрэн Архангай аймгийн Тариат сумын нутгаас Орхон-Енисейн руни бичигтэй том гэрэлт хөшөөг нээж олсон юм. Архангай аймгийн Тариат сумын нутгаас олдсон том гэрэлт хөшөө, Хөвсгөл аймгийн нутгаас олдсон Орхон-Енисейн руни бичигтэй гэрэлт хөшөөдийн бичгийг анх удаа монгол хүн тайлж уншсан нь М.Шинэхүү байв. Д.Наваан “Дорнод Монголын хүрлийн үе” (УБ., ?), В.В.Волков “Оленные камни Монголии” (УБ. 1981), Д.Цэвээндорж “Чандманийн соёл” (УБ. 1979) зохиолуудыг хэвлүүлжээ. Бичээс судлалын анги М.Шинэхүү, С.Г.Кляшторный, А.Очир, С.Харжубай нарын удирдлагаар ажиллаж Хөвсгөл аймгийн нутгаас том гэрэлт хөшөөний хэсгийг анх олж дараа нь үлдсэн хэсгийг нэмж олсон судалгааны үр дүнгээр М.Шинэхүү “Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал” (УБ. 1975), “Орхон Сэлэнгийн руни бичгийн дурсгал” (УБ. 1979) зэрэг нэгэн сэдэвт зохиол, хэд хэдэн өгүүлэл нийтлүүлжээ.

Хот суурин судлалын анги Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав, Шафкунов, Ц.Хандсүрэн, В.Войтов нарын удирдлагаар ажилласан юм. *Жич:* МЗТСХЭ-ийн Хот суурин судлалын анги 1971 онд ганц удаа ажиллан, дахин ажиллаагүй юм. Х.Пэрлээ нар 1971 онд Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Хар бухын балгаснаас хус модны үйсэн дээр бичсэн хэд хэдэн номыг нээж олсон юм. Эдгээр ном нь монгол бичгийн цагаан толгой, шашны судар, бөө буддын шашны заншил, мэргэ төлөг, цээрийн бичиг зэрэг байснаас Хууль цаазны хураамж бичиг нь нэн сонирхолтой дурсгал бөгөөд тэрхүү дурсгалыг олж судалсан нь Монголын археологийн судалгааны чухал нээлт хэмээн зүй ёсоор үнэлэх ёстой. Монгол улсын дундад зууны үеийн хот суурин судлах ангийг 1986 оноос Н.Сэр-Оджав удирдан Монгол гүрний нийслэл Хархорум хотын малтлага судалгааг явуулсан ба 1986-1990 он хүртэл хугацаанд зөвхөн сонины цөөн тооны мэдээнээс өөр дорвитой бүтээл туурвил гараагүй юм. Экспедицийн бүрэлдэхүүнд ажиллаж байсан Д.Баяр, В.Волков нар хожим цөөн хэдэн өгүүлэл бичсэн байдаг.

Угсаатны зүйн судалгааны анги С.Бадамхатан, Ц.Аюуш, Д.Тангад, Н.Викторова, Н.Л.Жуковская нарын бүрэлдэхүүнд ажиллаж Монголын угсаатны зүйн хамтын бүтээл, хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл туурвин Монгол-Зөвлөлтийн мэргэжлийн эрдэм шигжилгээний сэтгүүлүүдэд нийтэлсэн байдаг.

Г.Цэрэнханд

(Монгол улс, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн)

### **Ш.Нацагдорж ба Монголын угсаатны зүйн судалгаа**

Угсаатны зүйн судалгаа бол тухайн ард түмний амьдрах орчин, мэдлэг сэтгэхүйд суурьлан нийгэм соёлын олон асуудлыг хөндөж өнгөрсөн одоо, ирээдүйг харах боломжийг бүрдүүлдэг билээ. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн угсаатны зүйн салбарт 1950-иад оны сүүл үе гэхэд мэргэжлийн боловсон хүчин төрөн гарч онолын чиг баримжаатай болж судалгааны эх суурь тавигдсан тэр үеэс академич Ш.Нацагдорж гуай түүхийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж, Монголын угсаатны зүйн судалгааг төлөвшүүлэн, хөгжүүлэх талаар онцгой анхаарч байсан юм. Ялангуяа угсаатны зүйн судалгааны үүднээс ХХ зууны үеийн нүүдэлч малчдын аж төрөх хэвшил, соёл, ёс заншил хэрхэн яаж өөрчлөгдөж буй үйл явц болон хувьслын зүй тогтол зэрэг асуудлыг авч үзэх, нэгтгэж дүгнэх тухай сэдэв цоо шинээр тавигдаж, судалгааны арга зүйг боловсруулах, эх хэрэглэгдхүүнийг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах гэх мэт олон бэрхшээл тулгарч байсан тэр үед хүрээлэнгийн удирдлага, залуу судлаачид бидний мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор гадаад, дотоодын сургалт, хамтын ажиллагаанд өргөнөөр оролцуулах боломжийг дэс дараатай олгож байсан явдал угсаатны судлалд үнэтэй бөгөөд эерэг нөлөөлөл болж байлаа.

Монгол малчид бол нүүдэл соёлын үнэт зүйлсийг сонгодог хэлбэрээр нь бүтээж, зуунаас зуунд хадгалан хөгжүүлж, эдүгээ үетэй золгож тухайлбал, байгаль орчинтойгоо зохицон амьдрах эерэг харилцаанаас үүдэлтэй монголчуудын сэтгэлгээ, итгэл бишрэл, ёс заншил, мэдлэг ухаан зэргээр бусад ард түмний соёлоос ялгагдаж буй онцлогыг тодотгож баяжуулах гол зүйл бол хээрийн судалгааны эх хэрэглэгдхүүн болохыг Ш.Нацагдорж багш онцлон анхаарч, жил бүрийн эрдэм шинжилгээний төлөвлөгөөнд хөдөө орон нутагт ажиллах санхүүгийн зардлыг тусгаж 30-60 хоногийн хугацаагаар Угсаатны зүйн хээрийн судалгааг ажиллуулах нь тогтмолжиж, түүгээр ч барахгүй, Дархад, Цаатан ардын дунд суурин судалгаа хагас жил түүнээс ч илүү хоногоор явуулж байсан тухай мэдээ хүрээлэнгийн баримтын сан хөмрөгт хадгалагдаж байгаа юм.

Ер нь хүний аж төрөх ёс, зан заншлыг амьдралын гүнээс олж харах, байгаа байдлыг тусгана гэдэг нийгэм, соёлын хөгжлийн шууд тусгал болохын зэрэгцээгээр Шинжлэх ухааны судалгааны эх үндэс гэдэгт эргэлцэх зүйл үгүй билээ. Үүний тод жишээ үр дүн бол 1960-1989 онуудад явуулсан угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн 10 боть бүтээлээс тодорхой юм. Тухайн үес дэлхийн олон оронд угсаатны зүй, нийгэм соёлын хүн судлалын шинжлэх ухаан эрчимжиж, ард түмний амьдрах ухаан, соёл, ёс заншлыг судлах чиглэл, өргөжиж өөр өөрийн үндэслэл нотолгоог дэвшүүлэх замаар урагшлан хөгжиж иржээ. Үүнтэй нягт уялдаа бүхий сэдэвт ажил ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн угсаатны зүйн судалгааны төлөвлөгөөнд 1980-аад оноос тусгагдаж, Монголчуудын угсаа соёлыг нэгтгэн дүгнэсэн гурван боть хамтын бүтээлийг туурвиж (I боть. 1987, II ба III боть. 1996 онд) олны хүртээл болгосны зэрэгцээгээр 1985 онд Угсаатны зүйн бие даасан сектор болгон өргөжүүлэн бэхжүүлсэн зэрэг нь Ш.Нацагдорж академичийн үнэтэй хувь нэмэр болох нь тодорхой болно.



Чуан Рүн  
(БНХАУ, Өвөр Монголын  
Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн)

## **Аруг Юннань ван Тай Сан Гин номыг дэлгүүлэх линжи бичиг”-ийн тугтам шинжилгээ**

“Аруг Юннань ван Тай Сан Гин номыг дэлгүүлэх линжи бичиг” бол Юань улсын үеийн Юннань ван Аругаас Тай Сан Гин номыг дэлгүүлэхийн тусд буулгасан линжи бичиг болно. Тус хөшөөний бичгийн хамаарал бүхий агуулга, учир холбогдлыг нягтлах нь Юань улсын түүх судалгаа, жич Юань улсын үеийн монгол хэлний авиа зүй, хэлний зүй, үгсийн сангийн судлалд дутагдаж болшгүй үндсэн баримт, биет хэрэглэгдхүүн болох юм.

Үе үеийн олон эрдэмтний уйгагүй хөдөлмөр, шантаршгүй чармайлгаар дамжин тус хөшөөний бичээсийн тухай судалгаан далайцтай эрчимтэй явагдаж шинэ үр дүнд хүрэх талаар тодорхой ахицтай болжээ. Хэдийгээр эрдэмтдээс харьцангуй эртнээс тус хөшөөн бичээсийг судалж олон таамаг дэвшүүлж байсан боловч системтэй тайлбарлаж өнгөрсөнгүй, үг үсгийн утгыг тодруулсангүй, хэлний дуудлагыг тогтоож чадсангүй зүйлс бас буй.

Үүнд, тус өгүүлэлд энэхүү өвөрмөц дурсгалыг түүхэн баримтаар харьцуулан судлахын дагуу голдуу хөшөөн бичгийн агуулгыг тайлбарлан уншиж, задлан шинжилж, өнгөрсний судалгаанд шүүн тунгаалт хийж, оршиж бүхий алдаа оноог задлан шинжилж, түүхт хүн хэрэг учрын хамаарлын талаар үндэслэл дүгнэлт гаргахыг хичээв.

Б.Энхбаяр  
(Монгол улс, МУИС)

### **Академич Ш.Нацагдорж Монгол-Зөвлөлтийн харилцааны тухайд**

XX зууны нэрт түүхч, эрдэмтэн, академич Ш.Нацагдорж асан нь Монголын түүхийн шинжлэх ухааны хөгжилд ул суурьтай судалгаагаараа жинтэй хувь нэмэр оруулаад зогсохгүй, ШУА-ийн Түүхийн хүрээлэнг олон жил удирдаж орчин үеийн шинжлэх ухааны байгууллагын хэмжээнд хүргэн, залуу түүхчдийг сурган бэлтгэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гавьяатай нэгэн байлаа.

Академич Ш.Нацагдоржийн түүхийн судалгааны чиглэл зөвхөн дундад зууны үеэр хязгаарлагдахгүй, түүх, түүх бичлэг, археологи, угсаатан зүйн салбарын олон асуудлаар өргөн хүрээтэй судалгаа хийдэг, олон талын гүнзгий мэдлэгтэй, нөр их хөдөлмөрч, жинхэнэ эрдэмтэн хүн байсныг дурдах нь зүйд нийцнэ.

Монголын түүхийн шинжлэх ухааны олон асуудлыг улируулан судлахад онцгой анхаарч байсны нэг илрэл нь Монгол-Зөвлөлтийн харилцааны түүхийн асуудал юм. Академич Ш.Нацагдорж Түүхийн хүрээлэнгийн захирлын алба хашиж байхдаа Монгол-Зөвлөлтийн харилцааны түүхээр нэгэн сэдэвт хамтын бүтээл туурвих ажлыг санаачлан Монгол, Зөвлөлтийн нэртэй судлаач түүхч эрдэмтдийг хамруулан хоёр орны харилцаа хамтын ажиллагааны олон салбарыг түүхчлэн бичих, хянан тохиолдуулах ажлыг гүйцэтгэсэн нь энэ салбарын судалгаанд түүний оруулсан томоохон хувь нэмэр болсон билээ.

Энэ хүрээнд Монгол-Зөвлөлтийн харилцааны ч, Монгол судлалын ч, мөнхүү Орос судлалын ч нэгэн чухал сэдэв болох Монгол улсад ажиллаж байсан зөвлөлтийн мэргэжилтнүүдийн асуудлыг судлахын чухлыг ухамсарлан эл сэдвийг хүрээлэнгийн төлөвлөгөөт ажилд оруулан судлуульж байсныг онцлон тэмдэглэж энэ асуудлыг өгүүлэлдээ товчхон хөндөж үзлээ.

Юй Хай  
(БНХАУ, Өвөр Монголын Их сургууль)

**Чин улсын үеийн Онниуд баруун хошууны  
ван, гүн, тайж нарын Гэрийн үеийн  
бичмэлийг шинжлэх нь**

Чин улсын үед бичигдсэн “Ван гүнгүүдийн илтгэл шастир”, “Хаант төрийн гадаад аймгийн чухал бодлого”, “Монголын хошуу нутгийн тэмдэглэл” зэрэг хятад сурвалжис дахь онниуд хоёр хошууны язгуур гарлын тухай тэмдэглэл нь “Алтан хүрдэн мянган хигээст”, “Болор эрх” зэрэг монгол сурвалжисын тэмдэглэлтэй зөрөө оршиж буй. Хятад сурвалжистай харьцуулбал монгол сурвалжисын тэмдэглэл нь нэлээд нарийлаг боловч, мадаг алдаа олон байх учраас үе сүлжлийг оновчтой илтгэж дийлэхгүй байдаг. “Онниуд баруун хошууны вангийн угсаа болон үе улиран залгамжилсан он сар гавьяа зүтгэлийг тэмдэглэсэн илтгэл шастир” нь Бао Хунжюйгийн хятадаар орчуулан тэмдэглэсэн зүйл болох учраас түүний алдаш оношийг мэдэхэд хүчиртэй.

Тус өгүүлэлд Чингийн үеийн онниуд баруун хошууны ван, гүн, тайж нарын гэрийн үеийн бичмэлийн уг эх ба засаг яамны данс эвхмэлийг ашиглан Хачиуны угсааны үе сүлжлийг тодорхойлжээ.

